

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Лхава гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:*

1-7

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*

8-36

---

*1.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

9-13

*2.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

13-35

*3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

35-36

---

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар сарын 22-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Л.Мөнхбаатар, Ж.Сүхбаатар, Н.Учрал;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаар асуудал болох Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг тухайн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг хуралдаагүй учир хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасав.

**Нэг.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Шүүхийн сахилгын хорооны гишүүн С.Энхтөр, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ш.Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ялын бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Чимгээ, Нээлттэй нийгэм форумын менежер П.Бадамрагчаа, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу санал хураалгах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар:**

**Д.Цогтбаатар:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 7, 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7, 8, 13, 14 дэх заалт болгох:

7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

**1.Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:**

**Д.Цогтбаатар:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсэгт заасан анхан шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа эрүү, иргэний хэрэг, маргаан, эрүүгийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэрэг, маргааныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

**2.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Д.Цогтбаатар:** 1.Төслийн 2 дугаар зүйлийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “эсхүл тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан бол адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилуулах хүсэлтээ Ерөнхий зөвлөлд гаргаж болно.” гэснийг “эсхүл тухайн шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад хуульч бүртгүүлээгүй, шалгалтад тэнцээгүй, томилогдоогүй, сэлгэн ажиллах захиалгаар шүүгч хүсэлт ирүүлээгүй, зохист ачааллаас илүү ачаалалтай ажиллаж байгаа нь судалгаагаар тогтоогдсон бол дөрвөөс дээш жил ажилласан шүүгчийн зөвшөөрлийг үндэслэн адил

шатны өөр шүүхэд шилжүүлэн томилуулах саналыг Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид хүргүүлж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

**“1 дүгээр зүйл.**Монгол Улсын шүүхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“32.6.Ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүх болон сэлгэн ажиллах боломжгүй давж заалдах шатны шүүхээс энэ хуулийн 76.2, 95.4-т заасны дагуу шүүгч гишүүнээр сонгогдсон тохиолдолд тухайн шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлана.

32.7.Энэ хуулийн 32.6-д заасан шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг жилийн дотор сонгон шалгаруулалт зарлахгүй.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

**“3/46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг:**

“46.3.Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

**3.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:**

**Д.Цогтбаатар:** 1.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын 3 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

**“1 дүгээр зүйл.**Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

**4.Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Д.Цогтбаатар:** 1.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.**Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Мөнгөнцэцэг, Хуулийн хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, мөн хорооны гишүүн Д.Ариунтуяа,

Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Энх-Амгалан, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуулгад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Г.Амартүвшин, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

**Д.Цогтбаатар:** Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	5
Бүгд:	12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Хууль зүйн бодлогын газрын шинжээч Ж.Амгалан, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр 12 цаг 04 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр,  
Лхагвар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
10 цаг 11 минут.

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц 57 хувиар бүрдсэн байна. Ирцийг танилцуулъя.

Цогтбаатар, Ганибалын Амартүвшин гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн гэсэн ийм ирцтэйгээр өнөөдрийн хурал эхэлж байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал энэ чинь яг 4 байгаа даа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал 4 асуудал байгаа.

1.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2023 оны 11 дүгээр сарын

23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

2.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 4 гишүүн 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх, Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Ажлын хэсэг эд нар нь бид нар хуралдуулах гээд л явж байгаа. Ер нь явуулъя гэсэн юутай явж байгаа шүү дээ. Одоо ажлын хэсэг маань л хэр хурдан ажлуудаа урагшлуулаад явах юм. Би бас Мөнхцэцэг гишүүнтэй энийг яриад л байгаа. Тэгэхдээ өнөөдрийн юунд нэгэнт орж ирээгүй, Даргын зөвлөлөөр ч би хамгийн сүүлд таны асуудлыг бүүр яг ярьсаар байгаад сая оруулж ирлээ. Тэгвэл ингээд, харин тийм тэгэхдээ.

Ингээд хэлэлцэх асуудлыг энэ чинь ингэх нь. Ингээд горимын саналтай гишүүн алга байна сая хэлэлцэх асуудлаар. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн алга байна.

Одоо горимын санал гаргана. Яг түрүүн энэ Энхбаяр гишүүний ярьж байгаа асуудлаар бид нар энэ Шүгэл үлүүлэгчийн хууль дээр явуулах бодлоготой, явуулах чиглэлээр ажиллаж байна. Тэгэхдээ ажлын хэсэг дээр бүрэн бас хуралдаж асуудал эд нараа шийдэж бариагүй байна. Ажлын хэсэг хуралдаагүй, ажлын хэсэгтээ энийг хуралдуулах талаар яг ажиллаж байна. Тийм учраас уг нь өнөөдрийн энэ хэлэлцэх асуудалд ороод ирчихсэн байсан. Бас асуудал шийдэх иж бүрдэл хангагдаагүй байгаа учраас энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн ажлын хэсгийн энэ хуралдаан ирц бүрдээгүйтэй холбогдуулаад энэ асуудлыг хэлэлцэх асуудлын жагсаалтаас хасъя гэж байгаа юм. Энэ хэлэлцэх асуудлын энэ 2 дугаар асуудлыг хасъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудлаас 2 дахь заалт Шүгэл үлээгчийн тухай хууль хасагдлаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэгдүгээр асуудал. Засгийн газар 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Адъяаа гишүүн сууж байгаарай. Адъяаа гишүүнээ Адъяаа гишүүнээ, тийм. Адъяаа гишүүнээ та сууж байгаад энэ чинь хэд хэдэн санал босгох хэрэгтэй болчихоод байна. Харин тийм.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар, анхаарал сарниулаад байх юм энэ гүйцэд танилцуулж дуусаагүй байна.

**Засгийн газар 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн**

**Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.**

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулна. Амартүвшин гишүүнд микрофон өгье.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Шүүх байгуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн зарим хэсэг заалтыг гүйцээн боловсруулах нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай санал болон хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулж чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн эцсийн хувилбарыг бэлтгэлээ.

Шүүх байгуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн тухай танилцуулгыг хэлэлцэн шийдүүлж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Амартүвшин гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүд Л.Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ч.Хосбаяр Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн, Г.Алтанчимэг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн, Д.Мөнхтуяа Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн, Б.Батцэрэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, Н.Баярмаа Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч, Н.Отгончимэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Н.Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Насандэлгэр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, С.Энхтөр Шүүхийн сахилгын хорооны гишүүн, О.Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, Э.Бадамсамбуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга, Ш.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга, Д.Чимгээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ялын бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, П.Бадамрагчаа Нээлттэй нийгэм форумын менежер гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдрийн хуралд оролцож байна.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү?

Байхгүй байна. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Байхгүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3 дахь заалтын дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроор шийдэх 5 санал байгаа. Эдгээр саналаар Дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Бүгдийг нь тараачихсан байгаа шүү дээ. Та бүгд маань мэдэж байгаа энэ чинь яригдсан байгаа асуудал учраас. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ. Ингээд зарчмын зөрүүтэй санал хураалт явуулж эхэлье. 1 дүгээр санал энэ гуравны хоёроор босгох саналууд чинь байж байгаа шүү.

1.Шүүх байгуулах тухай хууль энэ шинэчилсэн найруулга, Шүүх байгуулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 7, 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7, 8, 13, 14 дэх заалт болгох. Энд ингээд хүснэгт явж байгаа та нарт чинь байж байгаа шүү.

7.Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүх

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж гэсэн энэ ингээд 3, 4 колумд байж байгаа шүү.

8.Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүх

Дархан-Уул аймаг

*Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж*

*13. Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүх*

*Орхон аймаг*

*Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж*

*14. Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүх*

*Орхон аймаг*

*Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж*

*Үүгээр тэгвэл саяын уншиж танилцуулсан томьёоллын дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.*

*75 хувиар санал дэмжигдлээ.*

*2023 оны 24 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хуралдааны хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтаар хураалгах ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 1 саналтай байгаа. 1 саналыг уншиж танилцуулъя.*

*Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/, Шүүх байгуулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.*

*1. Шүүх байгуулах тухай хуулийг шинэчилсэн найруулгын дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.*

*Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал.*

*1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:*

*“1 дүгээр зүйл. Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсэгт заасан анхан шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа эрүү, иргэний хэрэг, маргаан, эрүүгийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэрэг, маргааныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд шилжүүлнэ.” гэсэн энэ томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.*

*75 хувиар санал дэмжигдлээ.*

*3 дугаар санал.*

*2. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал гүйцээн боловсруулах.*

*1. Төслийн 2 дугаар зүйлийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “эсхүл тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан бол адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилуулах хүсэлтээ Ерөнхий зөвлөлд гаргаж болно.” гэснийг “эсхүл тухайн шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад хуульч бүртгүүлээгүй, шалгалтад тэнцээгүй, томилогдоогүй, сэлгэн ажиллах захиалгаар шүүгч хүсэлт ирүүлээгүй, зохист ачааллаас илүү ачаалалтай ажиллаж байгаа нь судалгаагаар тогтоогдсон бол дөрвөөс дээш жил ажилласан шүүгчийн зөвшөөрлийг үндэслэн адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилуулах саналыг*

Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид хүргүүлж болно.” гэж өөрчлөх. Санал хураалт.

Улсын Их Хурал тогтооно.””. Санал хураалт. Одоохон.

75 хувиар санал дэмжигдлээ.

75 хувиар санал дэмжигдлээ.

4 дүгээр санал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал.

6 дугаар санал. 2.Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал.

**“1 дүгээр зүйл.**Монгол Улсын шүүхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 3 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“32.6.Ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүх болон сэлгэн ажиллах боломжгүй давж заалдах шатны шүүхээс энэ хуулийн 76.2, 95.4-т заасны дагуу шүүгч гишүүнээр сонгогдсон тохиолдолд тухайн шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлана.

32.7.Энэ хуулийн 32.6-д заасан шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг жилийн дотор сонгон шалгаруулалт зарлахгүй.””. Санал хураалт.

**“1 дүгээр зүйл.**Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал хураалт.

5 дугаар санал.

Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

75 хувиар санал дэмжигдлээ.

**“3/46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг:**

7 дугаар санал. 3.“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

“46.3.Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”. Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ. Гишүүддээ баярлалаа.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин, Амартүвшин гишүүн ажлын хэсгээс Амартүвшин гишүүн танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

10.35 цаг

**Улсын Их Хурлын гишүүн Занданшатар, Тогтохсүрэн, Учрал, Цогтбаатар нарын гишүүд 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг, хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Энэ

үү? Л.Энхбилиг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ц.Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга, Д.Мөнхтуяа Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн, Н.Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Н.Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Д.Ариунтуяа Шүүхийн сахилгын хорооны гишүүн, С.Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Б.Оюунгэрэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга, Д.Эрдэнэчимэг Улсын дээд шүүхийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, Ж.Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч. Албан тушаалтнуудыг танилцуулж дууслаа.

Хуулийн төсөл санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, би өөрөө танилцуулна. Танилцуулга.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн танилцуулгыг хийе.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 2021-2030 онд хэрэгжүүлэх 5.1-д эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана гэсэн зорилтын хүрээнд шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө гэж, мөн ухаалаг засаглалын чиглэлд шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно. Ёс зүйн цогц чадамжтай шүүхийн хүний нөөц бэлтгэх суурь тогтолцоог бий болгож төгөлдөржүүлнэ. Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгон, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг

дээшлүүлнэ гэж шүүх эрх мэдлийн салбар дахь ил тод, нээлттэй байдал, цахимжилтын хөгжлийг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай хуулиудыг баталснаар төрийн аливаа байгууллага нээлттэй, ил тод байдлыг хангах, хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим засгийг бэхжүүлэх эрх зүйн орчинд ахиц гарсан. Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг дээшлүүлэх, цахимжилтыг нэвтрүүлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай тул Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүхийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах, шүүхийн үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдлыг дээшлүүлэхэд цахимжилтыг эрчимтэй нэвтрүүлэх, цахимжсан шүүхийн орчинд шүүхийн хүний нөөцийн оновчтой, зохистой удирдлагаар хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор Монгол Улсын шүүхийн тухай хуульд болон түүнд холбогдуулан Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Төрийн албаны тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсрууллаа.

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйл шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх асуудлыг зохицуулсан бөгөөд энэ зүйлийг өөрчлөн найруулах замаар шүүх нээлттэй, ил тод байх арга зам буюу хэлбэрийг нарийвчлан зохицууллаа.

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг

сонирхогч этгээд биечлэн болон цахимаар танилцах боломж бүрдэнэ.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр хуулийн хүрээнд шүүх шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу, дүрсний бичлэгээр хүргэхээр харилцааг тухайлан тусгалаа.

Ингэхдээ нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст, эс үгүй бол шүүхийн нээлттэй бусад цахим платформд заавал байршуулж, олон нийт бодит мэдээллийг цаг тухайд нь шуурхай авах боломжоор хангагдана.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуульд цахимжилттай холбогдуулан дараах өөрчлөлтийг тусгалаа.

Эрүү, иргэн, захиргааны хэрэг шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах бөгөөд ажиллагааны бэлтгэл хангах үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор Захиргааны хэргийг шүүхэд цахимаар хянан шийдвэрлэх ажиллагааг 2025 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс эрүү, иргэний хэргийн хувьд 2025 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэхээр тусгалаа.

Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх цахим платформыг ашиглах бөгөөд тухайн платформын онцлог, тавигдах шаардлагын талаар зохицуулсан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цахимаар харилцахад төрийн байгууллагын албан цахим шуудан иргэний e-mongolia өргөтгөлтэй цахим шуудан, Монголын өмгөөлөгчдийн холбооны цахим системд холбогдсон цахим шуудан, хуулийн этгээд таньж баталгаажуулах тохиргоо бүхий цахим шууданг ашиглана.

Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчтэй харилцах, нотлох баримт хүлээн авах, үнэлэх, шүүх хуралдааныг явуулах, шийдвэрийг хүргүүлэх зэрэг шүүн таслах бүх ажиллагаанд хамаарна.

3.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн эрх зүйн байдал тогтолцоог гадаад улсуудын ижил чиг үүрэг, түвшний шүүхийн сургалтын байгууллагын тогтолцоонд нийцүүлэн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи байхаар тусгалаа.

Шүүхэд цахимжилт нэвтэрч шүүхийн захиргааны хүний нөөцийг шуурхай удирдах уян хатан зохицуулалтаар хангахад шүүхийн захиргааны байгууллага хүний нөөцийн бодлого бие даан хэрэгжүүлэх шинэлэг заалтууд Монгол Улсын шүүхийн тухай хуульд тусгагдсан.

4.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 76.2, 95.4-д зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний 5-ыг, Шүүхийн сахилгын хорооны гишүүний 5-ыг шүүгчид дотроосоо сонгодог болсноор шүүгч нь сонгогдон өөр ажил эрхэлж буй тухайн шүүхүүдэд мөн тооны орон тоо дутагдаж, шүүн таслах ажиллагаанд ачаалал үүсэж, шүүхийн үйлчилгээний шуурхай байдал хөндөгдөж байна.

Шүүгч ийнхүү хуульд заасны дагуу өөр ажилд тодорхой хугацаагаар томилогдон ажиллах тохиолдолд тухайн анхан, давж заалдах шатын шүүхэд мөн тооны орон тоо нэмэх замаар шүүхийн ачааллыг тэнцвэржүүлж, шүүхийн үйлчилгээний шуурхай байдлыг хангахаар зохицууллаа.

5.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3-д тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн

хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн докторын, мэргэжлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс бүрдэхээр заасан бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүгчийн зэрэг дэвийн асуудлыг зохицуулаагүй орхигдуулсан тул шүүгчийн зэрэг дэвийн асуудлыг Монгол Улсын Их Хурал хуульд нийцүүлэн нарийвчлан тогтоохоор төсөлд тусгалаа.

6.Шүүгчийн туслахын албан тушаалд эрх зүйч ажиллах боломжтой байсныг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуульч ажиллахаар хуульчилсан нь бүх шатны шүүхэд шүүгчийн туслахын хомсдол бий болох шалтгаан болсон.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсгийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байх шаардлагыг хасах нэн яаралтай зайлшгүй шийдэх асуудал болоод байгаа тул энэхүү заалтад өөрчлөлт оруулахаар төслийг боловсрууллаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуулт асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

**Н.Алтанхуяг:** Надаа нэг асуулт байна л даа. Би их нарийн сайн танилцаагүй. Тэгэхээр Улсын Их Хурлын 4 гишүүний өргөн барьж байгаа хуулийн төсөл юм байна. Энэ хуулийн төслийн талаар Засгийн газар ер нь яг ямар санал өгсөн юм? Эсвэл Засгийн гишүүд нь өөрснөө санаачлаад барьчихсан юм уу, эсвэл Засгийн газартайгаа ойлголцоод барьчихсан юм уу? Тэгэхээр ойлголцоод барьчихсан болохоор Засгийн газрын



санал гэж ойлгож болох уу? Одоо би наадах дээр чинь юм асуух гээд байгаа нь прокурорын дэргэдэх мөрдөнг татан буулгадаг асуудлыг манай Улсын Их Хурлын 9 билүү, 10 гишүүн санаачлаад Засгийн газар бол санал өгөхийн тулд 1 сар хэртэй хүлээлгэдэг, тэр хоорондоо бид нар тэрнийг судлуулаад ингэж болохгүй юм байна гэдэг ийм санал боловсруулаад манай Засгийн газрын хурлаар ийм болохгүй юм хийж байна шүү, тогтолцооны шинжтэй устгал хийж байна гэдэг ийм асуудлаар санал өгсөн чинь Их Хурал руу шууруулж оруулж ирээд гэрлийн хурдаар баталсан түүхтэй. Ингэж энэ тогтолцоо эвдэн сүйтгэдэг ийм янз бүрийн юм болдог юм.

Ер нь энэ Засгийн газрын хажуугаар Улсын Их Хурлын гишүүдийн хууль тогтоох эрх мэдлийг буруугаар ингэж ашиглаж явдаг практик манайд бий боллоо. Тэр Цагаан суваргын 34 хувийг засаг байх ёстой гээд оруулахаар Их Хурал байхгүй болгодог гэх жишээтэй. Ингээд иймэрхүү юм байгаа юм. Энхбаяр сайд байгаа болохоор би хэлж байгаа юм. Та нар маань би үг хэлээд л байгаа шүү дээ энэ бүгдээрээ нэр дэвшчихсэн, морио унаад давчих гэж байхад чинь л ийм юмнууд хэлэлцээд байх юм. Нягталсан юм байгаа биз? Дараа нь асуудал үүсэхгүй биз л гэж би хэлж байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр гишүүн сайд нэмж хариулах юм байвал хариулчих байх.

Би энэ дээр Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсад хууль санаачлах эрхтэй субъектүүдийн хамгийн гол субъектүүдийн нэг. Тэгэхлээр Улсын Их Хурлын гишүүд үүнийг санаачлаад яг дүрэм, журмын дагуу Засгийн газарт саналаа танилцуулаад Засгийн газраас саналаа албан ёсоор аваад ингээд оруулж ирж байгаа.

Хуулийн үнэхээр гол зорилго Алтанхуяг гишүүнээ байгаа шүү энэ хуулийг нээрээ ил тод байлгая гээд. Сая

нүүрсний хэрэг хэлэлцээд л эхэлж байхад энэ шүүх нь өөрөө утгагүй байдалд орчхож байгаа байхгүй. Юу гэхлээр тэр хэрэг бүгдээрээ улс даяараа өчнөөн сар хэлэлцээд бүгдээрээ мэддэг болчихсон байсан. Тэгсэн тэнд ингээд л аль нэг шатад процессын хуульдаа аль албан тушаалтан нэг бичиг баримтыг нь нууцад авчихлаар тэр шүүх яах аргагүй хуралдааныг хаалттай хийхээс өөр гарцгүй болчихоод байдаг, улс даяараа мэдээд байгаа юм. Ингэнгүүт шүүхэд итгэх итгэл чинь өөрөө үнэхээр сууриараа ганхаж эхэлж байгаа байхгүй юу.

Тийм учраас шүүхийг Улсын дээд шүүхээс бүүр энэ саналыг гаргаад ийм бид нар энэ дээр чинь нээлттэй байхад бэлэн байгаа шүү, харин хууль чинь ийм байгаад байгаа, хуулиа янзалж өгөөч, шүүхээ жинхэнэ ил тод угаасаа байх зарчимтай. Үүнийгээ яг процессын хуулиудаа тусгаж өгч, ил тод болохгүй бол болохгүй байгаад байна гэдэг саналыг тавьсан. Тэгээд үүнийг оруулж ирсэн. Засгийн газрын зүгээс энэ дээр өөрийнхөө бас байр суурийг Энхбаяр сайд танилцуулчихмаар байна.

**Б.Энхбаяр:** Засгийн газар Цогтбаатар нарын гишүүдээс санаачилсан шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах, цахимжуулахтай холбоотой энэ хуулийн төслийг дэмжсэн санал өгсөн Засгийн газрын хуралдаанаар. Энэ хуультай холбоотойгоор Монгол улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр байдаг байнгын ажлын хэсгээр талуудын оролцоотойгоор энэ хуулийн үзэл баримтлалыг хэлэлцсэн байдаг.

Тэгэхээр өмгөөлөх талд, хүний эрхийн талд нь илүү тооцож шүүхийн ачааллыг хөнгөлөх, талуудад шүүхийн хаадаг мэдээллүүдийг нээлттэй болгох чиглэлээр энэ хуулийн төсөл боловсрогдсон.

Засгийн газраас тэр дотроо Хууль зүй, дотоод хэргийн сайдаас тухайлан дэмжиж байгаа хэд хэдэн асуудал байгаа. Тэр нь төрийн нууцад хамаарахаас бүх хэргийг Монгол улсын бүх шатны шүүх хаалттай хэлэлцэхгүй. Нээлттэй хэлэлцэнэ. Шүүх шударга ёсны баталгаа болох, хонгил болох хүнийг хэн нэгнийг хэлмэгдүүлэхгүй байх цорын ганц баталгаа нь нээлттэй байдал байгаа. Хүнийг яг ямар нотлох баримтаар буруутгаад байгааг нь хаалттай хэлэлцчихдэг. Хэвлэлээр урьдчилаад баахан хэрэгтэн юм шигээр мэдээлэл цагчихдаг мөрдөх алба. Тэгээд шүүх хурлаа хаалттай хийдэг.

Тэгэнгүүт олон нийтийн дунд энэ хүн гэмт хэрэгт нотлогдчихоод яригдаад байгаа юм уу, үгүй юм уу бүү мэд. Өөрсдөө бүүр гарцаагүй гэм буруутай хүн болохоор хаалттай хэлэлцчихээд, өөр мөнгөө төлөөд сүлжээгээрээ болохоор өөрийгөө гэм буруугүй юм шигээр мэдээлэл цацаад байдаг. Энэ хамгийн сүүлд болсон Нүүрсний Ганхуяг нарын хэрэг бол яг тийм. Энэ ямар ч нуугаад байх юм байгаагүй байхгүй юу. Цэвэр авлига, албан тушаалын хэрэг. Тэнд ингээд нотлох баримтууд нь бүрдчихсэн байдаг. Энд Сайнхүүгийн Ганбаатар нарын гишүүд орж ирчихсэн өмгөөлөгч нь хийгээд л, хамгаалаад л, Ганхуяг нарт жигтэйхэн хайртай болоод л, нүүрсчдийн гар, хөл болоод л, дуугараад л яваад байсан. Тэгсэн мөртөө тэр шүүх хуралдаан дээр нь болохоор гэм буруутай гээд ял авчихсан байдаг. Энэ нийт юм чинь өөрөө шүүхийн нэр хүндийг унагаад байна, шударга ёсон дээрх иргэдийн итгэлийг нураагаад байна гэдэг агуулгаар ерөөсөө энэ авлига, албан тушаалын хэргүүдийг шүүх хаалттай хийхгүй гэдгийг нь шууд хэлж өгөх гэж байгаа юм. Үүнийг бол Засгийн газар дэмжиж байгаа.

Шүүх тэгэхдээ гар бариад бугуй барина дотор нь юм шургуулаад байдаг юм. Би одоо энэ Шүүхийн хуулийн ажлын хэсгийг ахалсан. Алтанхуяг бид хоёр үүнийг их сайн мэднэ. Хамтдаа нэг

үзүүрт сэтгэлээр энэ хонгилыг нураах ажлыг, хуулиар нураах ажлыг хамтдаа хийсэн.

Тэр үед лоббидоод байсан зарим юмаа яг хууль санаачлах явцад бас шургуулсан байна. Жишээ нь, энэ бид нар энэ шүүгчдэд зэрэг, дэв олгодгийг болиулсан байхгүй юу. Тэргүүн түшмэл, гутгаар түшмэл ингээд. Шүүгч гэдэг чинь шүүгч байхгүй юу. Энийг нь ингээд чи арай илүү том шүүгч, чи арай илүү дарга шүүгч, чи арай илүү цэрэг шүүгч болгодог энэ юм байж болохгүй гээд энэ зэрэг, дэв олгодгийг нь нураачихсан юм. Тэгсэн чинь энэ 1 дүгээр зүйлийн 46.9, 10 дээр шүүгчдэд зэрэг, дэв олгоно гээд оруулаад ирчихсэн байна. Үүнийг Засгийн газар хэлэлцээгүй бөгөөд дэмжихгүй.

Хоёрт энэ шүүхийн академи байгуулна гээд ороод ирчихсэн байна. Энэ хүрээлэнгээ яриад байна уу? Зүсийг нь хувиргах гээд байна уу энэ? Бид бол дэмжээгүй юм. Над дээр яриад байхад нь. Энэ яг юу хийх гээд байна?

**Д.Цогтбаатар:** Алтанхуяг гишүүн тодруулъя.

**Н.Алтанхуяг:** Ер нь хэн хууль санаачлагч, хуулийн сайдын ярьж байгааг сонсвол ил тод болгох чиглэлд үнэхээр ийм өөрчлөлт хийж байгаа бол би хоёр гараа өргөөд дэмжинэ л дээ. Дундуур нь тэр Энхбаяр гишүүн бид нарын анхны өргөн барьсан концепт ингэж дундуур нь эвдэж байгаа бол тэрийг дэмжихгүй. Анх ярьсан шүү дээ ингээд хуульч, шүүгчдээ дотор нь дугаарлаад эхэлдэг. Бид нар зөндөө ярьсан. Тэгэхээр тийм ийм юмнуудаа бол хасаарай гэж би хэлэх гэж байгаа юм.

Өшөө ийм юм байгаа. Би энэ амьдралын практикийн л жишээ, кэйс гэж энэ орчин үед ярьдаг болчихсон юм шиг байгаа юм. Кэйс л яриад байгаа юм. Энэ хавтаст хэрэг нууц болдог ийм амьдралын жишээг би харсан. Би Сонгино дээр самбар дээрээ нэг нөхрийг шүүмжилчихсэн чинь намайг шүүхэд

өгөөд Сонгинын шүүх дээр очсон чинь эхний хавтаст хэрэг ийм зузаан юм байсан. Зүгээр ил тод би зургийг нь аваад л ингээд л ингээд явж байсан чинь хоёр дахь дээр нь шүүмжлүүлсэн нөхөр маань тагнуулаас хэдэн бичиг цаас тэр рүү шургуулчихсан юм шиг байна лээ 2 дугаар хавтас руу. Тэгсэн чинь бүхэлдээ энэ маань нууц

**Д.Цогтбаатар:** Гүйцээгээд Алтанхуяг гишүүний микрофоныг өгчихье.

**Н.Алтанхуяг:** Амьдралын жишээг хэлж байна. Энэ хоёрдугаарт нь ингээд тагнуулаас хэдэн бичиг ирсэн чинь 2 дугаар хавтсанд нууц болоод, буцаж манай ... цаг хугацаа буцаж гүйгээд 1 дүгээр хавтсанд дахиад нууц болчихоод. Би тэр шүүгчтэй маргасан юм. Үгүй ээ чи яагаад ийм дэмий юм яриад байгаа юм бэ? Би үүний чинь бүх зургийг авчихсан, ил тод байсан. Энэ Тагнуулаас ирсэн учраас энэ нууц. Тэгвэл энэ нь яагаад нууц болчихдог юм? Ингээд хэрэг бүхэлдээ нууц. Тэгээд тэр хэргийг нууцаар шийдээд дараа нь би тэр хүнийг дахиж шүүмжилж ярих эрхгүй миний амыг ингэж үдэхийн тулд ингэж хийсэн. Хөөе Энхбаяр сайдаа би амьдралын жишээ хэлж байна. Одоо жишээ нь, иймэрхүү юм дахиж гаргамааргүй байна шүү дээ. Тэр нууц гээд байгаа юмаа нууц л байдаг юм болбол болго л доо. Бүхэлд нь хавтаст хэрэг нь нууц болоод, шүүх хурал нь нууц болоод ингээд дууссан гэж амьдралын жишээ хэлж байна.

Би ер нь үүнийг та нар, засаг энэ хар. Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхэд бид халдахгүй. Тэгэхдээ тэр газрыг 100 жилээр гээд 100 мянган ам.доллар гэдгийг чинь 13 онд манай Засгийн газраас өргөн барихдаа 100 жилийг нь алга болгоод өргөн барихаар Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад, Их Хурлын ажлын хэсэг 1 бүлэг нэмээд татварын дэмжлэг, татварын бус дэмжлэг гээд татварын бус дэмжлэг дотор хийчхэж байгаа байхгүй юу. Бид нар иймэрхүү юмыг

хянадаг баймаар байна. Дээр нь байна шүү дээ. Энэ Засгийн газрын саналыг зүгээр л ингээд л энэ хавсарга төдий болгоод ерөөсөө ярьдаггүй байхгүй юу. Би бол эрх зүйн хувьд ингээд гишүүдийн санаачилсан юманд өгч байгаа Засгийн газрын саналыг жаахан серъёзны авч ярьдаг тийм зохицуулалт хийж өгмөөр байна. Тэгэхгүй бол тэр прокурорын дэргэдэх мөрдөн дээр манай Засгийн газрын санал чинь зүгээр л ингээд л энд хавчуулагдаад гишүүд харсан ч юм байхгүй, Засгийн газар өөрийнхөө саналыг тайлбарладаг болмоор тийм механизм баймаар юм шиг байгаа юм. Ингэвэл бид нар энэ хууль санаачлах эрхийг хулгайгаар ашигладаг юмыг л би хаах гээд байгаа юм л даа.

Түүнээс биш энэ Цогтбаатар даргыгаа муулж болохгүй байх тээ? Ингээд сайхан ил тод болгоё, нээлттэй болгоё гэж байгаа нь үнэн юм болбол би дэмжмээр л байна.

**Д.Цогтбаатар:** Та микрофоноо хаачих. Алтан гишүүн ээ яг тэгье. Яг таны ярьж байгаа аливаа ийм жижигхэн асуудлаар, утгагүй асуудлаар ингээд л сүүлдээ хаалттай болгоод л ингээд юу болж байгаа нь мэдэгдэхгүй явдгийг л одоо ерөөсөө хай гэж байгаа юм. Энэ бол авлигатай тэмцэхэд хамгийн гол юм нь дарга нар үзэн ядаад л толгойг нь аваад өгнө гээд байгаадаа биш, хэн ч үгүйсгэх аргагүй нээлттэй яваад бүх хүн тэр шүүгчийн хурал дээр хэлж байгаа санал, байр суурь, хууль тайлбарлаж байгаа байдал, өмгөөлөгчдийн гаргаж ирж байгаа нотлох баримт энэ хэлэлцүүлгийг чинь иргэд шууд хараад мэдрэх боломжтой болж байгаа байхгүй юу.

Тэгэхлээр шударга ёсны мэдрэмж хүн болгонд бий. Зөндөө олон хуульчид тэрийг чинь харж байгаа. Тэгэхлээр бодитоор яг энэ ямар болж байна шийдвэр гэдгийг мэдэх боломж гарч байгаа юм. Энхбаяр сайдаа энэ дээр нээрээ нэг юмыг бас тодруулаад хэлмээр байна. Энэ хуулийг гол санаачлагчдын нэг

Энхбаяр сайд өөрөө. Би тэрэнд талархаж байгаа. Харин өөрөө Хууль зүйн сайд яг асуудлыг эрхэлж байгаа сайдын хувьд санаачлагчдын юунд бүрэлдэхүүнд орох боломжгүй байна гээд өөрөө энэ санаачлагчдынхаа юунд нэр нь тусгагдаагүй байгаа боловч энд гол санаачлагчдын нэг нь Энхбаяр сайд.

Харин энэ Энхбаяр сайдтай ярьж байх үед нээрээ зэрэг, дэв эд нар яригдаагүй үнэн. Тэгэхдээ Энхбаяр сайдаа энэ Засгийн газрын тэмдэглэл байж байна. Энэ дээр чинь байна шүү дээ Засгийн газрын тэмдэглэл дээр 1.1-д нь энэ зэрэг, дэвийн асуудлыг харин яриад энэ зэрэг, дэв гэсэн ингэж нэмэхээр тусгасныгаа зэрэг, дэв, зиндаа гэж тодотгож өөрчилбөл зүгээр байна гэсэн бүр саналаа бас өгчихсөн байгаа шүү.

Алтанхуяг гишүүнд хэлэхэд Засгийн газрын саналуудыг бид нар бараг бүгдийг нь эндээ оруулж өгсөн байгаа бас. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Алтанхуяг гишүүн их чухал асуудал хөндөөд байгаа юм. Тэр нь энэ олон жилийн турш манай мөрдөх албад ялангуяа төрийн болон албаны нууцтай холбоотой эсвэл хүний эмзэг мэдээлэл гэдгээр эмзэг мэдээлэл гэдэг чинь юу ч байж болох байхгүй юу. Тэрийгээ их тийм өргөн хүрээнд тайлбарладаг. Энийгээ ингээд нууц гэдэг байдлаар хүнийг гэмт хэрэгт яллагдагчаар татдаг, тэгээд таны хэлсэнчлэн гэмт хэрэгт сэрэгдээд буруутгагдаж байгаа тэр этгээдэд нь хуулбарлаж өгдөггүй. Ингээд шүүхээр орчихлоо, шүүхийн шийдвэр гарлаа. Шүүхийн шийдвэрт дотор хүртэл байгаа нууц мэдээлэл гээд тэрийг нь гардуулж өгдөггүй. Нөгөө хүн чинь ял авчхаад байна шүү дээ. Хүн өөрөө ямар хэрэгт буруутгагдаж байгаа юм, ямар нотлох баримтаар буруутгаад байгаа юм хүнийг гэдгийг нь өөрт нь өгөхгүйгээр ер нь ял шийтгэдэг юм гэж ямар юм байх вэ.

Тийм учраас энэ асуудлыг Засгийн газар ер нь би бол хэлээд байгаа шүү дээ. Би 5 үе шаттай юм оруулж ирнэ гээд энэ ер нь. Эхнийхийгээ оруулаад батлуулсан. Энэ хоёр дахь нь энэ шүүхийн нээлттэй байдал, гурав дахь нь ирэх долоо хоногийн Засгийн газрын хурал дээр орж хэлэлцэгдэх юм. Тэр нь яг эрүүгийн процесстoo, процесс дотор хүний эрхийг зөрчөөд байгаа яг тийм хэсгүүдийг засах тийм багц хуулийн төслийг манай байнгын ажлын хэсэг сая 2 долоо хоногийн өмнө хэлэлцчихсэн юм. Одоо ингээд Дээд шүүх, Прокурор гээд бүх байгууллагуудынхаа саналыг аваад дуусаж байгаа юм. Хүний эрхийн Комисс гээд.

Тэгээд Засгийн газрын хуралдаанаар оруулаад энэ хэргийг мөрдөх, нотлох процесст өмгөөлөгчийн эрхийг нэмэгдүүлэх гэж байгаа юм ерөөсөө. Өмгөөлөгчийн эрхийг мөрдөгчийн эрхтэй эн тэнцүү болгох гэж байгаа юм. Аль нэг нь давуу биш. Хүнийг хэн нэгнийг яллах процесс биш байхгүй юу энэ чинь. Энэ гэмт хэргийг илрүүлэх, нотлох процесс явагдаад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ процессын оролцогч нь мөрдөгч, өмгөөлөгч аль алийг нь эрхийг нь хангаж байж энэ процесс хууль ёсны дагуу явагдана.

Бид нар өнөөдөр хүнийг эрүүдэн шүүсэн тухай, эрүүдэн шүүж байгаад хүнийг гэмт хэрэг ноогдуулсан тухай сүүлийн 2 сар тодорхой үйл явдлуудыг иргэд, олон нийт хараад сууж байна шүү дээ. Хэнийг ч хууль зөрчиж, хууль зөрчиж нотлох баримт цуглуулж байгаад яллаж болохгүй. Энэ ерөөсөө номер нэг зарчим байхгүй юу. Тэр хүний гэмт хэрэгтэн эсэх бол хоёр дугаар асуудал болчхож байгаа юм.

Тийм учраас гэмт хэргийг илрүүлэх, нотлох, яллах бүх процесс эхнээсээ дуустлаа хуулийн хүрээнд явагдах ёстой. Үүнийг яаж манах вэ? Ганцхан мөрдөгчийн хүчээр биш. Мөрдөгчид эрх олгож биш, мөн өмгөөлөгч буюу тэр хүний эрхийн манаач

гэж бид орчуулж болно өмгөөлөгчийг. Энэ хүний эрхийн манаачийн эрхийг нэмэгдүүлж байж процессын шударга ёс буюу чекин балансыг процесс дээр дотор нь хангах ийм өөрчлөлтийг ирэх долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж өргөн барих гээд байгаа юм. Энэ бол гуравдугаар ажил нь. Тэгээд дахиад хоёр ажил үлдэж байгаа.

**Д.Цогтбаатар:** Нээрээ сая Энхбаяр гишүүн аягүй чухал юм ярьчихлаа. Бид нар ч гэсэн түрүүн Шүүхийн тухай хуулийг хэлэлцээд дагаж гарах энэ тогтоол батлахдаа энэ өмгөөлөгчийн эрхийг оролцох нөхцөл, боломжийг илүү сайжруулж оруулж ир ээ, тийм хуулийн төсөл оруулж ир гэж чиглэл өгсөн. Тэрний дагуу Засгийн газар ажиллаж байгаад баяртай байна. Нэг юмыг энэ зөвхөн өмгөөлөгч чинь тэгш эрхтэй байх нь зөвхөн юутай мөрдөгчтэй биш, ер нь бол бүх төрийн албан хаагчид нь төрийн төлөөлөлтэй адилхан байх ёстой байх. Тэрийг нээрээ.

Яагаад гэвэл хууль шүүхийн өмнө Монгол улсын иргэн бүгд ижил, тэгш эрхтэй, төртэйгөө ч яг маргаж байгаа тохиолдолд төртэйгөө ч ижил эрхтэй байгаа. Тэгэхлээр тэр хэрэв хууль боловсруулах явцдаа аливаа нэгэн хязгаарлалт байгаа бол яг шүүхийн өмнө очоод мэтгэлцээд, маргаж байгаа бол шүүгчийн хувьд тэнд бүгд ижил эрхтэй байж байгаа шүү дээ. Нөгөө хүн шүүгч өөрөө буруу гэдгийг нь дараа нь дотоод итгэл үнэмшил, хуулиа баримтлаад тогтоох хүртэл энэ дээр ямар нэгэн эрхийн ялгаа байхгүй гэдэг тэр юугаа зарчмаасаа бас хуулиа боловсруулахдаа бодоосой гэж бодож байна.

Хамгийн гол нь тэр шүүх дээр нээрээ мэтгэлцэх энэ боломжийг бүрэн хангаж өгөх ёстой. Тэр зарчмын аягүй зөв юм сая яригдаж байна. Ингээд Б.Энх-Амгалан гишүүнд микрофон өгье.

**Б.Энх-Амгалан:** Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааг нээлттэй явуулах, ил тод болгох, шүүхийн хараат бус байдлыг хангах гэдэг хамгийн чухал асуудал. Үүнийг би хоёр гараа өргөөд дэмжиж байгаа юм. Энд би гурван юм асуух гээд байна.

Хэрэг бүртгэлд мөрдөн байцаалт явуулж байгаа байгууллага эхлээд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гаргадаг. Энэ хулгайч ингэсэн гэнэ ээ, тэгсэн гэнэ ээ гээд л. Ингээд л баахан сайт энэ тэргүүгээр явуулж явуулж байгаад, гэрчээр дуудахдаа энэ сайт дээр ийм юм гарсан байгаа учраас таныг энэтэй холбоотой асууж байгаа юм. гэдэг. Тэрнийхээ дараа хэд хоногийн дараа яллагдагч болгочоод энэтэй холбоотой юмнуудыг ингээд шалгаж байгаа юм гээд ингээд яваад өгдөг. Тэгээд тэрийг хэргийнхээ талаар зохиол биччихдэг. Тэрийгээ гаргаж ирээд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаад унадаг.

Ингээд ийм хүмүүс шалгагдаж байгаа, энэ хүмүүс ингэчихсэн. Энэ нь эргээд нийгмээр шүүлгээд унадаг. Өө муу хар хулгайч, авлигачин тэр мэр гээд л баахан шүүж шүүж шүүж шүүж байгаад баахан юм хавтаслаж тавьж байгаад шүүх рүү өгчихдөг. Тэр дотор нь юу байдаг вэ гэхээр зэрэг хэрэгтэй, хэрэггүй баахан компанийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйлгээ баахан юмнуудыг хавтаслаж хавтаслаж байгаад дотор нь ганц нэгхэн юм оруулчихаад тэдэн хавтаст хэрэг гээд шүүхэд шилжүүлсэн, одоо шүүх яахыг харна. Бид нар болчихсон шүү. Шүүх яахыг харна. Шүүх шударга биш шүү дээ гээд ингээд байдаг. Шүүх нь нийгмийн шахалтад орчхож байгаа юм. Энийг яах вэ? Шүүгээд үнэн, зөв нь энэ байна гээд гаргаад ирэх гэхээр энэ бол авлигач шүүгч байна гэхих гээд байдаг, шударга бус шүүгч байна гэхих гээд байдаг, эсвэл тэр нийгмийнхээ юмыг дагаад явчих гэхээр хүний хувь заяагаар тоглочих гээд байдаг. Нэг дэх нь ийм асуудал байгаа юм. Энийг цаашид нь яах вэ? Энэ шүүхэд нөлөөлдөг, хөндлөнгөөс нь нөлөөлдөг

байдлыг яаж арилгах вэ? Энэ дээр яаж тусгах вэ.

Хоёр дахь нь энэ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн энэ үйл ажиллагааны явцад гарсан шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж энэ бүх юмнууд ингээд ил болгоод ингээд авъя гэхээр

хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гэрчүүдийн өгсөн мэдүүлгийн бичлэгийг авъя гэхээр авч өгдөггүй. Хэргийнхээ материалтай танилцаад хуулаад ингээд хувилаад авъя гэхээр чи хуулаад ав гэдэг. Тэр материалаас чинь яаж өдөржин хуулаад ингээд гараар бичээд сууж байх юм бэ. Ийм цаг үе биш шүү дээ. Шууд зургийг нь дараад дараад дараад явчих ийм бололцоо бүрдүүлж өгдөггүй.

Тэдэн сарын тэдний өдөр би ингээд мэдүүлэг өгсөн, тэгэхдээ би дөнгөж ороод гарчихсан шүү гэдэг ийм юмыг нь бичлэгийг нь авъя даа гэхээр өгдөггүй. Энэ чинь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хүний эрх, эрх чөлөөг хангаж байгаа асуудал биш болчихоод байгаа байхгүй юу. Дээр нь шүүхийн энэ асуудал дээр яадаг вэ гэхээр зэрэг шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүхийнхээ хуралдааныхаа бичлэгийг ингээд авъя гэхээр бичлэгийг нь өгдөггүй. Цагаар хязгаарлаад чи энэ хугацаанд үзээд тэр тогтоол болон шийдвэртэйгээ танилц гээд ингээд суулгачихдаг.

Ингэхээр шүүхийн тогтоол, шийдвэр, захирамж чинь буруу гараад ирэхээр тэнд авагдсан гэрчийн мэдүүлэг, тэнд авагдсан яллагдагчийн, өмгөөлөгчийн өгсөн мэдүүлгүүд чинь энэ дээр зөрөөд байна гэдэг юм бичлэг дээрээ байж байгаа учраас тэрийгээ авъя гэхээр өгдөггүй. Тэгэхээр энийг өгдөг болгох талаас нь, өмгөөлөгчийн эрхийг хангах талаас нь хоёрдугаарт ягхийх вэ гэдэг юм би хэлэх гээд байгаа юм.

Гуравт нь бол энэ шүүх хуралдааны бичлэгийг заавал ингээд

цахим мэдээллийн санд ил тод, нээлттэй байршуулна. Цахим мэдээллийн платформ заавал байршуулна, нээлттэй байна гээд байгаа юм. Энэ тодорхой хугацаатай байхгүй бол ингээд л байнга байж байдаг. Тэрийг нь хүмүүс татаж авч ашиглаад л, харахгүй юу худлаа гэвэл энд байна гээд л ингээд л. Тэр тухайн хүнд ирж байгаа дарамт болж хувирна шүү дээ бас. Энийг хугацаатай болгох асуудал дээр юу байна?

Дөрөв дэх асуудал юу байна гэхээр зэрэг энэ бичлэгүүдийг эвлүүлбэл яах вэ, тасалбал яах вэ, утгыг нь алдагдуулбал яах вэ? Манайх чинь ёстой янзын янз

**Д.Цогтбаатар:** Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Б.Энх-Амгалан:** Тэгээд нөгөөдөх нь ярьснаасаа шал өөр юм болоод эвлүүлэгдээд, таслагдаад, утга агуулга нь зөрөөд, эвлүүлсэн жүжиг болж хувираад ингэчихээр зэрэг цаана нь хүний эрх, эрх чөлөө, шүүхийн гаргасан шийдвэр зөв ч юм шиг, буруу ч юм шиг нийгэмд ойлгогдох вий. Тэгэхээр зэрэг энэ дөрвөн юман дээр маш онцгой анхаарахгүй бол энэ маань өөрөө эргээд нуухыг нь авах гээд нүдийг нь сохлов гэдэг шиг ил тод болгох гэж байгаад бүүр шийдвэр нь өөр болоод ингээд гуйвуулагдаад явчих ийм рүү орчих вий дээ гэж ингэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ дээр анхаармаар байгаа юм.

Яагаад гэвэл хуурамч хаягаас нөгөөдөх чинь таслаад л ингээд л өөр болгоод шидчихвэл тэрийг чинь тогтоох гэж ёстой бөөн юм болно шүү дээ. Эсвэл тэр бичлэг хувилагддаггүй байх ч юм уу ийм ийм юмнууд бас анхаарахгүй бол энэ маань ингээд нээлттэй тавьчихаар дуртай хүн авч тасална шүү дээ. Тэрийгээ л бас бодмоор байгаа юм. Ийм 4 асуулт дээр би хариулт авъя.

**Д.Цогтбаатар:** Ажлын хэсгээс хариулах уу? Мөнхтуяа шүүгчийн микрофоныг өгье. Байз та 2 дугаар микрофон дээр очоод суучих уу? Би

харахгүй эндээс гэрэл цохиод, 2 дугаар микрофон дээр очоод суучих. 2 дугаар микрофон.

**Д.Мөнхтуяа:** Өглөөний мэнд хүргэе. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах энэ зорилгын хүрээнд бол сая Энх-Амгалан гишүүний асуугаад байгаа асуудлууд бүрэн яригдана. Ихэнх асуулт бол энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын журамтай холбоотой юмнууд та асуугаад байгаа юм байна.

Тэгэхээр ерөнхий зохицуулалтаараа Шүүхийн тухай хуульд ийм өөрчлөлт оруулж энэ нээлттэй, ил тод байдлаа хангахгүй бол болохоо байлаа гэдгийг Улсын дээд шүүх энэ 2024 оны 2 сард, оны өмнөөс эхлээд бид нар судалгааны ажлууд хийгээд үндсэндээ энэ хаалттай байдал чинь бүүр замбараагаа алдлаа, үүнийг ерөөсөө ямар асуудал байна гэхээр ерөөсөө хуулиудад нь бөөн тээгтэй юм байна лээ. Ингээд болохгүй байна, энэ хуулиудаа өөрчлөхгүй бол ерөөсөө болохгүй юм байна гээд ингээд 2 сарын 23-нд нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцээд 7 дугаартай тогтоол гарсан. Үүгээр хууль санаачлагчид санал хүргүүлж, энэ шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж өгөөч гээд. Энэ тогтоолыг Засгийн газарт хүргүүлсэн, Ерөнхийлөгчид хүргүүлсэн, Их Хурлын даргад хүргүүлсэн. Ингээд манай үндсэн санал маань Засгийн газар, Хууль зүйн сайд бол дэмжээд ер нь энэ асуудлаа гаргаад ир ээ гээд, бид нар энэ Шүүхийн Сургалт, судалгааны хүрээлэнгээр судалгаа хийлгээд яг ямар ямар хуулиудад байгаа тээг процесст ирээд яг яаж нөлөөлж байна вэ гэдгийг бүгдийг нь ингээд гаргачихсан байгаа.

Ингэхээр энд саяын ярьж байгаа асуудлууд, түрүүн Алтанхуяг гишүүн бас ярилаа нэг бичиг нууцын тэмдэг дараад л нууц, үнэн. Одоо захиргааны процесс дээр гэхэд Монголбанк нууц гээд

Монголбанкны тэмдэг дараад л нэг ширхэг хуудас А4-ийн цаас ирлээ, тэр хэрэг бүхэлдээ хаалттай. Тагнуулын байгууллагаас ирсэн бичгийг үндэслээд л өнөөдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлд нь хааж байгаа.

Яагаад вэ гэвэл тэр хуулиараа өөрөө тэр нууцынхаа хуулиар тэгэх тийм зохицуулалттай байгаа. Шүүх яаж ч чадахгүй энэ дээр. Тийм учраас бид нар энэ процесс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад наад нууцын хуулиудаа хязгаарлаж өгөөч ээ, Хувь хүний мэдээлэл хамгаалах хууль байна. Энэ хуулиар чинь ерөөсөө хувь хүн өөрөө зөвшөөрөхгүй бол юуг ч ил гаргах боломжгүй. Байгууллагын нууц байна. Байгууллага өөрөө нууцаа дотоод журмаараа зохицуулчихдаг. Байгууллагын нууцын тэмдэг дараад ирлээ, тэр шүүх дээр явж байгаа юм нь ил гарах ямар ч боломжгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ гол үндсэн концепц бол ерөөсөө энэ Байгууллагын нууцын хууль, Албаны нууцын хууль, тэр Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулиа тэр өөр харилцаанд нь энэ уул нь зохицуулалтын харилцаа нь өөр харилцаа зохицуулж байгаа хуулиуд байхгүй юу. Хүний хувийн мэдээллийг эзнийх нь зөвшөөрөлгүй гуравдагч этгээд халдаж аваад ил болгохыг л хориглох зохицуулалттай.

Гэтэл энийг аваачаад энэ шүүхийн процесст хэрэглэнэ гэдэг ийм юмыг шүүхийн хуульдаа байж байдаг, процессын хуульд байж байдаг. Ингээд л тэр хуулийг бариад л бүгд хаалттай. Энэ дээр жишээлбэл, энэ төслийн 12.16-г хасаж өгөөч ээ.

Яагаад вэ гэвэл энэ төсөл дээр байгаа 12.16 чинь яг одоо энэ байдал чинь яг буцаад буцаад хэвдээ очлоо. Яагаад вэ гэвэл эзэн өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нээлттэй гээд байгаа юм. Энийгээ болиод өгөөч ээ гээд тэгсэн. Энэ 4 гишүүний санаачилж байгаа хуулийн төсөл дээр Засгийн газраас санал авъя

гээд Улсын дээд шүүхэд ирүүлснийг 5 сарын 7-ны өдөр бид нар нийт шүүгчдийн хуралдаанаараа хэлэлцээд яг бид нарын өгсөн санал дээр ийм ийм юм чинь болохгүй байна, жишээлбэл, энэ төслөөсөө 12.16-г хасаад өгөөч ээ гээд албан ёсны саналаа бичгээр хүргүүлсэн байгаа. 5 сарын 7-ны өдрийн биш ээ 5 сарын 7-ны өдрийн хэддүгээр тогтоол билээ? Ингээд бичгээр хүргүүлчихсэн. Улам сайжруулъя гэдэг саналаар.

Тэгэхээр яг энэ гишүүдийн ярьж байгаа энэ асуудал бүгд энэ асуудлаас үүдэлтэй. Одоо энийг дагаад процессын хуулиудад өөрчлөлт орох ёстой. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйл гэж байдаг юм. Шүүхийн нээлттэй, ил тод байдал гэдэг гарчигтай мөртөө доторх заалтууд нь бүгд хаалттай. Яаж хаах вэ, яавал хаа авах вэ л гэдэг заалтууд. Энийгээ энэ гарчигтайгаа нийцэхгүй байна, нээлттэй байна гэдэг гарчиг мөртөө дотор нь дандаа ингэж хаана, тэгж хаана. Энийгээ дандаа ингээд нээлттэй байлгана, ингэнэ гээч ээ гээд бүүр ингээд томъёоллоор нь бид нар ингээд бэлдээд өгчихсөн байгаа. Яг энэ томъёоллоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийг өөрчлөөд өгөөч ээ.

Дээр нь эрүү, иргэн, захиргааны шүүхийн процесст тэр албаны нууц тэр байгууллагын нууцын хууль хамаарахгүй гэдгийг бүүр заагаад өгөөч. Үнэхээр хаах шаардлагатай бол шүүх өөрөө төрийн нууц юм уу, яагаад хаалттай байгаа юм гэдэг үндэслэлээ дурдаад шийдье. Хаах уу, нээх үү гэдгээ.

Тэгээд хэрвээ шүүгч хаагаад байвал тэр шийдвэрт нь гомдол гаргаад хянуулъя. Хянаад энэ шүүгч буруу хаасан байна, нээ гэдэг юмыг нь хэлж өгөөд нээлгэе. Ийм процессыг ингээд цогцоор нь оруулаад өгөөч ээ гэдэг санал бол Дээд шүүхийнх. Энэ.../минут дуусав./

**Д.Цогтбаатар:** Мөнгөтуяа гишүүний микрофоныг нь өгье. Та нэмээд

наад ярьж байгаа юм чинь аягүй чухал байгаа учраас гүйцэд сонсьё.

**Д.Мөнхтуяа:** Тэгэхээр манайхаас өгсөн саналыг одоо яг энэ хэлэлцэх гээд байгаа төсөл заримыг нь аваад, заримыг нь аваагүй. Жишээлбэл, би бүр 12.16 төслийн тэрийг бол ерөөсөө одоогийн байгаа хуулийн зохицуулалт чинь 12.16 байхгүй юу. Өөрөө зөвшөөрвөл нээнэ, зөвшөөрөхгүй бол хаана гэдэг. Яг буцаагаад оруулаад ирчихсэн. Энэ болохгүй ээ. Энийгээ хаагаад өгөөч ээ, энийг хас.

Дээр нь манайхаас ирүүлсэн санал дээр бид нар ингээд нээлттэй байдлыг яаж хангавал шүүхийн процесс болохоор байгаа вэ гэдгийг бүүр ингээд нэг бүрчлэн үг, үсгээр нь, зүйл заалтаар нь саналаа өгчихсөн байгаа юм. Яагаад вэ гэвэл процессыг бид нар сайн мэдэж байгаа учраас ингээд биччихвэл энд хаагдана, ингээд биччихвэл энэ асуудал арилна гэдгийг бид нар мэдээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар, би энэ хууль санаачлагчид хүсэлт гаргах гээд байгаа нь Улсын дээд шүүхээс 5 сарын 7-ны өдрийн албан ёсны бичгээр ирүүлсэн санал дээр байгаа энэ саналуудыг аваад өгөөч ээ. Энэ саналыг энэ хуулийн төсөлдөө тусгаад, энэ хуулиа батлаад өгөөч ээ гэж ингэж хэлэх гээд байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Энх-Амгалан гишүүн. Хариулт дээр тэгье. Хариулт дээр Энхбаяр гишүүнд микрофон өгч хариулт гүйцээж хариулуулмаар байна бас энэ дээр. Мөнхтуяа шүүгчид одоо яг хууль санаачилж байгаа бидний зүгээс энэ санаануудыг бид нар бүгдийг нь оруулсан байгаа. Саяын энэ өөрчлөлтүүд бол Засгийн газар хариулах ёстой. Яагаад гэвэл бид нар процедураараа угаасаа Засгийн газраас бас санал авах ёс ёстой учраас энэ саналуудаа авсан байгаа.

Харин энд нэг зүйлийг цохоод хэлмээр байна. Мөнхтуяа гишүүн бол ер нь шүүхээс энийг ил тод болгоё гэдэг



санал анх гарч, энийг дэмжиж явсан шүү. Би энийг энд онцгойлон цохож хэлмээр байна. Яагаад гэвэл буруутныг хайх болохлоороо дандаа шүүхээс ингээд л хайгаад л яваад байдаг.

Тэгтэл эсрэгээрээ шүүх чинь үгүй ээ бид нарт шударга ажиллах боломж олгоод өгөөч ээ, Их Хурал дээр та нар наад хуулиа өөрчлөөд өгөөч ээ, түүнээс бид нар энэ хуулиудаас чинь болоод ийм нэр хүнд зүүгээд яваад баймааргүй байна гэдэг саналыг бас гаргасан шүү.

Тэгэхлээр энийг манай олон түмэн ч гэсэн мэдэж байх ёстой. Асуудал чинь энэ тогтолцоо бид нар ярихлаараа хэн нэгэн хүнийг ингээд, эс үгүй бол бүтэн байгууллагаар нь авч буруутгаад байх биш, энэ дотор чинь тийм нөхцөл байдал руу хөтөлсөн аягүй олон хүн анзаарахгүй жижиг жижиг юмнууд нь явсаар байгаад төрийн бүхэл бүтэн нэг салбарын олон нийтийн итгэл даах энэ нөхцөл байдал чинь өөрөө хөндөгдөөд гуйвчихсан, ганхчихсан явж байгаа. Одоо энийг л засах гээд процесс явж байгаа шүү.

Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Мөнхтуяа шүүгчийн үгэнд үндэслэл байна. Энэ 12.16-г янзалсан юм. Энэ томьёолол нь болохгүй байгаад байгаа юм. Яасан юм бол? Бид нар чинь хамгийн сүүлд би өөрөө сууж байгаад бид нар чинь бүүр яаман дээр, манай яамныхан хаана байна? Энэ чинь хууль санаачлагч нь биш учраас байхгүй байгаа юм байна шүү дээ тийм ээ. Тэгээд Дээд шүүх, прокурор, өмгөөлөгч, Криминалистикийн холбоо гээд бид нар яг хамт суугаад яг энэ заалтыг болохгүй байна. Яг Мөнхтуяа шүүгчийн үндэслэлээр хаалттай хэвээрээ байх юм байна гээд бид нар чинь бүүр 2, 3 цаг ярьж байгаад бүүр томьёолол гаргаад өөрчилсөн байхгүй юу. Тэгэхээр тэр томьёоллоо яг өгсөн л гэж надад хэлсэн юм даа. Тэгсэн чинь энэ хуучнаараа яачихсан байна шүү дээ. Тэгэхээр энэ

Мөнхтуяа шүүгчийн үндэслэлд үндэслэл байгаа. Тэгэхдээ яг Дээд шүүхийн өгсөн томьёоллоор бас хийж болохгүй байсан бас.

Яагаад гэхээр тэр бид би байнгын ажлын хэсгээ яриад байгаа байхгүй юу. Энд чинь бүгд сууж байдаг. Дээд шүүхийн өгсөн томьёолол бас болохгүй байсан юм. Тэгээд бүгдээрээ сууж байгаад яг энэ асуудлыг энэ хамгийн зүй зохист хувилбар юм байна гээд томьёолол бичсэн чинь тэр томьёолол нь зарим нь процесс дээр ороод, зарим нь юу яасан байна. Тэгэхээр энийг хэлэлцүүлгийн явцад тэр байнгын ажлын хэсгээс эцэслэсэн буюу бүх талуудын ойлголцсон тэр оновчтой томьёоллоор нь хийхгүй бол тийм агуулга бас байна. Тийм үндэслэлтэй байгаад байна Мөнхтуяа шүүгч.

**Д.Цогтбаатар:** Тэгье, тэгвэл. Аан за микрофон 3 дугаар микрофон өгье.

**Н.Баасанжав:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Энх-Амгалан гишүүний энэ бичлэг ингээд байнга нээлттэй байгаад байх, түүнийг нь цааш нь гуйвуулж дамжуулаад байвал яах вэ гэсэн энэ асуултад хариулъя.

Тэгэхээр энэ хуулийн төслийн 12.5, 12.9 дээр шүүх хуралдааны дуу, дүрсний бичлэгийг хэрхэн яаж, хаана байх тухай заачихсан байгаа юм. Тэгэхээр цахим платформд байршуулна гэхчхэн хугацаа заагаагүй. Тэгэхээр энэ дээр хугацаа хэрэгтэй. Энэ бол тэр бичлэг ямар зорилготой, ямар хугацаанд байршаад байгаа юм, ямар ач холбогдолтой юм, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа явцад тэр үедээ л хэрэгтэй юм уу, цаашид байнгын байж байх юм уу?

Хоёрт нь энэ хөрөнгө мөнгө, техникийн асуудал. Бид нар энэ дуу, дүрсний бичлэг гэдэг 1 өдөр 106 шүүх хуралдааны танхим байна. Зэрэг 106 шүүх хуралдаан болж байгаа нэг л цаг мөчид. Өдөрт 10 шүүх хуралдаан бол

ингээд үржүүлээд үзвэл хэдэн бичлэгийг хийх ёстой юм, түүнийг нь хэр хугацаанд байршуулах юм, хэнд ач холбогдолтой юм гэдгээ харах ёстой. Тэгэхээр хуулийн үндсэн зорилго маань нээлттэй байя, түүнд байгаа энийг олон түмэн шүүх хараат бус шударга ажиллаж байгаа, хэргийн оролцогчдоос ямар асуудлыг тавиад энэ эцсийн дүндээ энэ хэрэг чинь шийдвэрлэгдээд байгаа юм гэдгийг л мэдэг гэж байгаа юм.

Тэгэхээр энэ зорилгодоо нийцүүлээд энэ шүүхийн платформ дээр энэ шүүх хуралдааны нээлттэй явсан энэ бичлэгийг байриих хугацаа өөрөө түүндээ нийцсэн хугацаатай, чанартай, эргээд энэ нь хүнд ойлгомжтой байх ёстой. Зөвхөн зарим хэсэг нь яваад, зарим хэсэг нь явахгүй байх юм уу. Гэтэл 3, 4 өдөр үргэлжилж байгаа хэргийг яах вэ гэх мэт асуудал хөндөгдөх юм.

Тэгэхээр энэ дээр журмыг батлах хэрэгтэй байгаа юм. Яг энэ цахим платформд ямар хугацаанд, хэрхэн яаж байршуулах гээд. Энэ хууль дээр цаашид үүнийг дамжуулахдаа эх сурвалжийг нь дурдаад, гуйвуулахгүй, хэсэгчлэхгүйгээр дамжуулна гэсэн заалт байгаа юм. Тэгэхээр энэ заалтаар бол харьцангуй хангагдана.

Гэхдээ тэр 3, 4 өдөр, энэ 12.8 дээр байна л даа шүүх хуралдааны дуу, дүрснийг бичлэгээр дамжуулах тохиолдолд өөрчлөлт оруулах, хэсэгчлэн хасалт хийх, засварлахыг хориглоно гээд энэ бүх этгээдэд хориглож байгаа юм. Тэгэхээр үүн дотор аль нэг талын өмгөөлөгч, сэтгүүлч хамаараад байгаа. Тэгэхээр энэ дээр нэгэнт дамжуулбал 3 өдрийн бичлэгийг бүтэн дамжуул, үгүй бол алийг нь ч хийхгүй гэсэн утга байгаад байгаа юм.

Гэхдээ эдгээр заалтууд процессын хуульд бас баталгаажиж орох хэрэгтэй байгаад байгаа юм. Сая Мөнхтуяа шүүгчийн хэлж байгаа, Энхбаяр сайдын хэлж байгаа ч гэсэн тэр Нууцын тухай хуульд нь, Хувь хүний нууцын тухай хууль,

Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд нь яг шүүх дээр ирчихвэл энэ нууц чинь байхгүй шүү гэдэг заалт энэ 3 хуульд, төрийн нууцыг мэдээж хязгаартай орохыг ойлгож байна. Нөгөө 2 нууцад үргэлжлүүлж энэ заалт орохгүй бол Шүүхийн тухай хуулийг нь 12-т орсон заалт бас хэрэгжих, бүрэн хэрэгжих, утгаараа хэрэгжих боломжгүй болно. Энэ платформын дамжуулах бол процессын хуульдаа бас нэмэгдэж суухгүй бол бас л бүрэн утгаараа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Би Энх-Амгалан гишүүний бас асуултад гүйцээгээд хариулчихъя.

Энх-Амгалан гишүүний хөндөж байгаа тэр гэрчээр дуудаж байгаад яллагдагч болгочихдог, өөрийнх нь гэрч гэдэг мэдүүлгийг нь өөрийг нь буруудахад нотлох баримт болгож ашигладаг энэ бол нэлээн серъёзны асуудал болчихсон байгаа, хавтгай мөрдөх албаны бүүр ингээд арга барил болчихсон. Хүнийг хэлмэгдүүлдэг. Энийг болиулж ерөөсөө хэрхэвч нотлох баримтаар тооцохгүй гэдэг асуудлыг би 3 дугаар ангийнх нь юмыг яриад байгаа юм. Ирэх 7 хоногт энийг бүүр хатуу зааж өгч хариуцлагажуулж байгаа юм. Бүүр хориглож байгаа юм.

Хоёрдугаарт, тэр нууц гээд байгаа юмыг дөнгөж сая, одоо Засгийн газраар хуралдаж байна л даа. Би дөнгөж сая Засгийн газрын хуралдаанаар Хүний эрхийн багц хуулийн төсөл Засгаар хэлэлцүүлээд, Улсын Их Хуралд өргөн барихаар болсон. Энэ 29 хууль байгаа юм. Энэ хуулийн нэг хууль нь Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулж, орж ирж байгаа юм. Тэгээд албаны нууцыг төрийн байгууллагуудын дарга нар үзэмжээрээ албаны нууцын тамга дардаг явдлыг болиулж байгаа.

Өөрөөр хэлбэл, энэ иргэдийн нэгдүгээрт, мэдэх эрхтэй холбоотой асуудал.

Хоёрдугаарт, сая энэ шүүхээс яг яриад байгаа энэ байгууллагууд энэ нууцын тамга дарснаас болоод шүүх хурлууд энэ хаалттай болоод байгаа гэдгийн чинь нэг үндэслэл нь энэ байгаад байгаа байхгүй юу. Энийг ерөөсөө болиулж байгаа юм. Байгууллагын дарга нар өөрсдөө албаны нууц гэдэг тамга дарахгүй болгож байгаа юм. Нууцын хуульд өөрчлөлт оруулж ирж байгаа ийм бас өөрчлөлтүүд явж байгаа гэдгийг бас хэлье.

**Д.Цогтбаатар:** Мөнхтуяа шүүгчийн микрофон өгье. 2 дугаар микрофон.

**Д.Мөнхтуяа:** Нэмээд хэлчихье. Ер нь Шүүхийн тухай хууль бол эрүүгийн болоод иргэний, захиргааны шүүхүүдэд нэгдмэл хэрэглэх ийм зарчим тогтоогоод байгаа юм. Нээлттэй байх талаар шүүх яах вэ гээд. Яг энэ зарчим өөрөө эрүүгийн шүүх дээр, иргэн дээр, захиргаан дээр очихоороо бас сална.

Жишээлбэл, Эрүүгийн шүүх дээр насанд хүрээгүй хүүхэд байдаг юм уу, бэлгийн хүчирхийллийн хэргийг заавал нээлттэй байна гэж тийм юм байхгүй. Хаах юмаа хаана. Хүний эрхийг хамгаалах үүднээс хаах үйл баримт, хаах шүүх хурлууд байгаа. Тэрийгээ эрүүгийн процессынхоо хууль дээр тусгайлаад заагаад өгчихнө. Ийм ийм хурлуудыг хаана, эсвэл зөвшөөрөл авна. Тийм ээ гэр бүлийн хүчирхийлэл юу байдаг юм.

Иргэний процесс дээр иргэний шүүх дээр жишээлбэл бас хаах юм байгаа. Гэр бүл цуцалсантай холбоотой гэдэг юм уу их тийм хувийн орчинд болж байгаа хэргийг заавал олон нийтэд нээлттэй байлгана гэх шаардлагагүй байна. Тэгэхээр бас тодорхой хэргүүд дээр хаалттай байна гээд ингээд заачихна. Тэгэхээр энэ процессын хуулиуд өөрөө ингэж салах учраас шүүхийн

хуульдаа зарчмаа нээлттэй тавиад өгөөч гээд байгаа юм. Энэ хүрээндээ жишээлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй байна гэдэг зарчим байхгүй юу. Тэр тусгайлсан хуульдаа юугаа хаах вэ гэдгээ нарийвчлан заана.

Харин Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хувьд бол захиргааны шүүх нэлээн онцлогтой шүүх. Иргэн хоорондын маргаан шийдэхгүй. Нэг талд нь дандаа захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг. Тэр агуулгаараа Захиргааны процессын хуулиар Захиргааны шүүхийн үйл ажиллагаа 80, 90 хувь нь нээмээр байгаа юм. Нээмээр байгаа юм. Тэгэхээр илүү Эрүүгийн шүүх, Иргэний шүүхээс хамгийн илүү нээлттэй байх процесс бол захиргаан дээр байх боломжтой байна гэж бид харж байгаа юм.

Тийм учраас Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг Дээд шүүхээс өгсөн саналаар 9 дүгээр зүйлийг нь бүр ингээд 9.1, 9.1.1 гээд бүр ингээд томъёолоод өгчихсөн байгаа. Тэр саналаар нээлттэй байх байдлыг нь Захиргааны процессын хууль дээр хуульчлаад өгөөч ээ гэж ингэж хүсэж байгаа юм. Одоо эрүү дээр бол сая Энхбаяр сайд хэлж байна байнгын ажлын хэсэг Эрүүгийн процессын хууль дээр байгаа. Тэд нар санаа зовох юм байгаа. Зөв, тэр нь процессынхоо хуулиар орчихно. Иргэн дээр ч гэсэн тусдаа орчихно. Захиргааны процессыг бол нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцээд хамгийн нээлттэй байх ёстой бүх шүүх хурлууд нь ер нь нээе. Үнэхээр төрийн нууц, тэр нийтийн эрх ашиг, сонирхолд ноцтой хор хохирол учруулж болзошгүй эд нар гэдэг юм нь тогтоогдвол тухай бүрд нь шүүх өөрөө ийм ийм учраас хаалттай явуулах ёстой юм байна гэдэг үндэслэлээ заагаад шийдье. Тэр шийдвэр нь хянагдъя гэж байгаа юм дээд шатын шүүхдээ.

Тэгэхээр ийм байдлаар бид нар оруулчхаад байгаа юм. Манай саналыг бас хууль санаачилж байгаа гишүүд маань бас анхаарч үзээч гэж ингэж хүсэх гэсэн юм.

**Д.Цогтбаатар:** Энэ нэгэнт аягүй чухал асуудлууд яригдаж байгаа. Их энгийн товчхон хууль орж ирж байгаа юм шиг боловч цаанаа яг энэ шүүх тогтолцоо нь аягүй суурь баганыг хөндөж байгаа учраас энэ дээр бид нар ер нь гүйцээгээд санаа, оноонуудаа хэлчих ёстой гэж бодож байна.

Би энэ дээр нэг зүйл яг хууль санаачилж байгаа хүний хувьд хэлчихмээр байна. Юу гэвэл ер нь шүүх угаасаа ил тод байх манай Монгол улсад өнөөдөр үйлчилж байгаа хуулийн чинь зарчим нь байж байна шүү дээ. Тэр нь хуульдаа суучихсан байж байгаа.

Гэтэл яг процессын хуулиар нарийвчлаад хаах бүх боломжуудыг нь аваачаад нээгээд өгчихсөн. Боломжуудыг нь биш, хаах үндэслэлүүдийг нь тавиад өгчихсөн. Тэгээд хаагаад хаагаад явчхаж байгаа байхгүй юу. Тэгэхлээр эд нарыг нь авна гэдэг угаасаа өнөөдрийн хийж байгаа хууль бол өнөөдөр үйлчилж байгаа хуулийнхаа хүрээнд яг энэ хэрэгжүүлэлтийг илүү зохицсон болгож, тодотгож, илүү боловсронгуй болгож байна гэсэн үг, нэг.

Хоёрт гэхлээр цаашидаа ер нь энэ хуулийг хэрэгж, би энийг бүүр онцгойлон хэлмээр байна. Яагаад гэвэл хуулийг хэрэглэж байх явцад энэ дээр ямар нэгэн үл ойлгогдох байдал үүсээд, тайлбар хийх шаардлага гарахад гол баримтлах зарчим юу вэ гэхлээр хууль санаачлагчид юуг хүссэн гэхлээр энэ ил тод байдлаа л хангах үүднээсээ аль болох энийг хаахгүй байх үүднээс энд л зориулагдаж хийгдэж байгаа. Тэгэхлээр энэ дээр ерөөсөө л ялт ч үгүй хаах нөхцөл байдал амьдрал дээр ингээд л үүсэхэд нээх талдаа л эхлээд л бодох ёстой. Тэгж байгаад дараагийн дүн шинжилгээ чинь зайлигүй хаах ямар

нөхцөл үүсэж байна, тэрийгээ авч шинжилж хаах ёстой.

Жишээлбэл, энэ яг энэнтэй холбогдуулаад Энх-Амгалан гишүүний түрүүн ярьж байна шүү дээ бичлэгийг шууд өгөх ёстой. Энэ ингээд заагдсан байгаа юу? Тэгэхлээр энэ дээр үгээрээ шууд 24 цагийн дотор өгөх ёстой гэж заагаагүй байж болно. Энэ бол цаашаа гүйцээгээд үүний дагуу гарах хууль, журамдаа энэ тусгагдаад явах ёстой. Тусгагдаагүй байсан ч амьдрал дээр хэрэгжихдээ энэ хуулийг гаргахдаа нээлттэй л болгож байгаа бол тэр шууд өгдөг байх ёстой, шууд авдаг байх ёстой.

Яагаад гэвэл тэр 24 цаг хаалттай байж болохгүй шүү дээ гарсныхаа дараа. Тэгэхлээр энд өөрөөр хэлбэл, дараа нь тэр дүрэм, журам ч гэсэн гарахдаа энэний чинь санаа нь нээлттэй болох гэж байгаа учраас жишээлбэл, энэ бичлэг эд нарыг шууд ямар нэгэн хаалтгүйгээр өгөх боломж, техникийн боломж байгаа бол шууд өгөөд явдаг байх ёстой. Энэдээ энэ үндсэн зорилгодоо нийцсэн ийм дүрэм, журмууд цаашаа гарах ёстой шүү гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгэхлээр энэ талаасаа юмнуудаа бас бодож ажиллах ёстой. Сая энэ дээр гарч байгаа Энхбаяр сайдаа тэр танай санал эд нартай тэгвэл арай өөрчлөгдөөд орчихсон байгаа бол ажлын хэсэг дээр энэ юмнууд орсон байгаа байх. Би Байнгын хороон даргын хувьд яг үзэл баримтлалдаа нийцүүлж энийгээ ажлын хэсэг дээрээ хэлэлцэх эсэхээ шийдсэнийхээ дараа ажиллаад, засаад явах ёстой шүү.

Яагаад гэвэл энийг оруулж ирсэн чинь харин гуйвуулаад өөр болгочихсон байж ёстой болохгүй. Яагаад гэвэл үзэл санаа бол нээлттэй гүйцээ. Нээрээ тэр нээлттэй байх дээр ийм байгаа шүү. Ерөөсөө ямар ч эргэлзээгүйгээр шууд нээх юм бол олон нийтийн эрх ашгийг хамарсан, ялангуяа энэ захиргааны шүүх энэ дээр ямар ч тайлбар байхгүйгээр

нээлттэй байх ёстой. Яг хувь иргэний асуудал байна, нийтийн асуудал биш нээрээ гэр бүлийн яг хоёр хүний хоорондын асуудал, иргэний шинж чанартай ийм юмнууд дээр зайлиггүй хувь хүний мэдээллийг хаах юмнууд байвал энэн дээр нь би бас нээлттэй байгаа.

Гэхдээ л хүмүүс нэг юмыг ойлгох ёстой. Яагаад гэвэл гэр бүлийн маргаан дээр зарим шийдвэрүүд чинь нийгмийн харьцаанд өөрчлөлт оруулахуйцаар ийм хэрэглэгдэнэ шүү дээ хууль дээр. Тэгэхлээр ер нь хүмүүс шүүх дээр очиж байгаа бол энэнээс цааш бид нарын асуудал бол тэр улсын нууц тэр тагнуул, мөрдөх ажиллагааны бүүр нарийвчилсан нууцтай л холбоотой биш бол нээлттэй байх нь байна шүү гэдгээ ч гэсэн иргэд ойлгож байх ёстой. Тэр гэртээ гэр бүлийн хүчирхийлэл хийгээд авгай, хүүхдээ зодож байгаа нөхөр тэр мэдээллээ хаалттай байлгах эрх би байхгүй гэж бодож байгаа юм. Хүүхдийнхээ мөнгийг төлөхгүй байгаа, зугтаад байгаа нөхдүүд тэрийгээ нууц байлгах эрхгүй гэж бодож байгаа юм. Тэд нар чинь хүрч ирээд ярихлаараа миний нууц шүү дээ, миний орлогын, хувийн орлогын нууцтай гээд олон юм ярих байх. Тийм юм байхгүй. Энэ тэгэхлээр бас яг захиргааны шинж чанартай нийгмийн асуудлыг бүхэлд нь хамраагүй хувь хүний асуудал хамраад байгаа юм шиг боловчиг яг цаад утгаараа энэ чинь нийгэмд нийтлэг болоод, хэрэгжээд, үргэлжлээд яваад байгаа юмыг зогсоогоод тухай асуудал болохлоор энэ хувь хүний асуудал байхаа болчхож байгаа байхгүй юу. Энийг зогсоолгох хэрэгтэй байгаа.

Тэгэхлээр яг энэ дээрээ үндэслээд энэ ажлын хэсэг цаашидаа ажиллахдаа энийгээ бодолцож ажиллана шүү. Зарчим нээлттэй байх ёстой. Иргэд шүүх дээр очих юм бол ер нь бараг хувийн асуудал байхгүй шүү, нээлттэй болно шүү гэдгээ л ойлгодог байх ёстой.

Тэгвэл ингээд Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Шүүхийн салбарын нэр хүндийн асуудал иргэдийн дунд ямар байгаа вэ гээд энэ унасан байгаа байдал, шүүгч нар хараат бусаар ажилладаг байдал эд нар гээд энэ болгоны чинь цаад үндэс нь ерөөсөө энэ хаалттай, ил тод байж чаддаггүй энэ байдлын л үндэс юм байна гэж би бол харж байна.

Тийм учраас эртээрхэн хүртэл Шүүхийн хөгжлийн бодлогын баримт бичиг батлах дээр би бас яг энэ санааг хэлж байсан. Цаашидаа нээлттэй, ил тод байлгах ёстой, шүүх бараг өөрийн гэсэн хэвлэл, мэдээлэлтэй байх ёстой юм байна. Иргэн хүн зүгээр өнөөдөр сонирхсон шүүх хурлаа үздэг байх бололцоог гэрээсээ зурагтаар үздэг байх бололцоог, гар утаснаасаа үздэг байх бололцоог л олгочих хэрэгтэй юм байна.

Тэгэхээр тэнд шүүхийн оролцогч, шүүгч шийдвэрээ хэрхэн яаж явуулж байна, шүүх хуралдаанд хэрхэн яаж хандаж байна, нотлох баримт нь хэрхэн яаж бүрдсэн юм байна, хэргийн оролцогч нар, яллах дүгнэлт үйлдэж байгаа прокурорын байдал, мөрдөн байцаагчийн хэрэг боосон байдал, хэргийн оролцогчийн тайлбар, мэдүүлгүүд эд нар үнэхээр иргэдэд ил тод, нээлттэй байгаад үнэхээр шүүгч эцсийн шийдвэрийг хэрхэн, яаж хараат бусаар, бие даасан байдлаар гаргаж байна гэж энэ чинь зөвхөн шүүхийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал биш, хэргийн оролцогч нарын, олон оролцогч нарын үйл ажиллагаанд нээлттэй, ил тод байдлууд үүсэх юм байна. Өмгөөлөгчийн байдал, хариуцлагатай байдал, мөрдөн байцаагчийн, прокурорын гээд. Тийм учраас ерөөсөө энэ Шүүхийн тухай хууль батлагдаад 3 орчим жил гаран болж байна. Энэ хуулийн чинь амин судас нь, сүнс нь энэ ерөөсөө энэ ил тод, нээлттэй байдлын асуудал юм байна. Асуудал юм байна.

Тийм учраас үнэхээр хараат байдлаар ажиллаад байгаа, хэн нэгний

хөндлөнгийн үүрэг даалгавраар ажиллаад байгаа энэ шүүгч нарын энэ хууль бус үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, нөгөө талаар шударгаар ажиллаж байгаа шүүгч нарын үйл ажиллагааг бас ил тод, нээлттэй болгох. Үнэхээр энэ шүүгч чинь үнэхээр шударга юм байна шүү гэдгийг энэ ил тод, нээлттэй байдлаас л харуулна шүү дээ. Иргэд цаашидаа ер нь энэ шүүгч бол үнэхээр шударга шүүгч гэдгийг энэ байдлаа бүүр баталгаажуулж явна. Энэ шүүгч ер нь асуудалд үнэнчээр, шударгаар асуудалд хандаж чаддаггүй, илтэд ийм шийдвэр гаргадаг гэдэг ийм шүүгч нарын үйл ажиллагаа ч гэсэн ил тод, нээлттэй болж байна. Хар, цагаанаараа гэдэг юм уу, тос, усаараа ялгарч гарч ирэх юм байна. Энэ бол ил тод, нээлттэй байдал.

Тийм учраас цаашидаа шүүгч нар хонгилддог гэдэг юм уу, хууль бусаар гэдэг юм уу, илтэд гэдэг юм уу ийм хууль бус шийдвэр гаргах энэ асуудал цаашидаа аажмаар багасна гэж би хувьдаа бодож байгаа юм. Тийм учраас энэ шүүхийн ил тод, нээлттэй байдлын асуудал бол үнэхээр чухал хууль энд орж ирж байна.

Харин талаар манайх зүгээр энэ хэрэгжих хугацаа нь 7 сарын 1-нээс гэсэн байна. Амжих юм уу? Энийг дагаад төсөв санхүүгийн, эдийн засгийн тооцоолол нь юу байна вэ? Дэд бүтэц нь яаж манай энэ орон нутгийн шүүхүүдээр бүрдсэн юм бэ? Та сая хэлж байна 1 цагт өдөрт дор хаяж дунджаар 130 гаруй хуулиуд зэрэг явагдаж байна. Тэгэхээр энийг дагаад төсөв, санхүүгийн асуудал хэрхэн яаж шийдэгдэх юм? Шүүхүүд чинь энэ нээлтээ явуулах тал дээр нь энэ ажил хариуцсан хүмүүс, орон тооны асуудал хэр яригдах юм, тоног төхөөрөмжийн асуудал нь хэр бүрдсэн байдаг юм? Одоо манай шүүхийнхний цаасан архивын хадгалалт бас л үнэхээр хэцүү байгаа шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Стандарт бус ийм орчинд л хадгалагдаж байгаа хавтаст хэргүүд. Одоо цаашидаа шинээр энэ цахим хэргүүдийн энэ архив, мэдээллийн сан бий болж гарч ирж байна шүү дээ. Энийг цаашидаа яаж ямар

орчинд хадгалах юм, хэн хадгалах юм, аюулгүй байдлыг нь хэн яах юм? Тэрэнд бас халдахыг үгүйсгэхгүй шүү дээ гэх мэтчилэн ингээд асуудлууд үүсэж байна. Энэнтэй холбоотойгоор энэ асуудлуудыг энэ хуульд яаж оруулж ирсэн бэ? Сая Мөнхтуяа шүүгч үндсэндээ бараг хэлж байна.

Бас хэдийгээр ил тод, нээлттэй байдлын шүүх гарчиг нь тийм байгаа боловч 100 хувь бүрэн дүүрэн гүйцээж чадахгүй байна, дагасан бас олон хуулиудад өөрчлөлт оруулах хэрэгцээтэй байна. Хувь хүний мэдээллийн, Байгууллагын нууцын энэ хуулиудад өөрчлөлт оруулж байж энэ асуудлаа шийдэхгүй бол хагас дутуу байна шүү гэдгийг хэлж байна шүү дээ. Тэгэхээр энийг хууль санаачлагч яах юм, цаашидаа оруулж ирэх юм уу, оруулж ирэхгүй юм уу? Тэгж байж энэ жинхэнэ утгаар нь ил тод, нээлттэй байдлын асуудал ярихгүй бол зүгээр ил тод, нээлттэй байдлын малгай өмсүүлчхээд доор нь бүх юм хаалттай, дагасан гэдэг юм уу, суурь хуулиуддаа энэ асуудлуудыг нь нээлттэй болгож өгөхгүй бол энэ асуудал чинь зүгээр нэр төдий болох ийм асуудал үүсэж байна. Тийм учраас тэр бүх суурь хуулиуд дээр нь энэ асуудлуудыг нь нээж өгөх асуудлыг нь хэзээ нээх юм бэ?

**Д.Цогтбаатар:** 2 дугаар микрофон Мөнхтуяа шүүгч хариулъя.

**Д.Мөнхтуяа:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим хяналтын шатын шүүх хуралдаануудыг ер нь бүрэн нээлттэй болгоё, лайв стрийм /live stream/ болгоё гэсэн. Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцээд танхимын саналыг дэмжээд, бэлтгэл ажилдаа орёо гээд манай Улсын дээд шүүхийн Тамгын газар үндсэндээ бэлтгэл ажилдаа орчихсон, Шүүхийн ерөнхий зөвлөл маань дэмжиж энэ дээр бас туслалцаа үзүүлж ажиллана. Ингээд тэр тоног төхөөрөмж бүх юм нь бол бид нар 25 оны 1 сарын 1-нээс шууд дамжуулалт буюу нээлттэй шүүх хурлуудаа явуулъя

гэдэг ийм төсөөлөлтэй байгаа юм. Чадвал 10, 11 сараас юм уу туршилтын ганц юунуудаа явуулж үзье гээд. Энэ өөрөө бас дангаараа шүүхээс хамаарахгүй байгаад байгаа юм. Гэнэтийн ийм юм чинь төсөв, хөрөнгө байна, дээр нь тоног, төхөөрөмж байна, хүн хүч байна, ядаж дундаас нь хакердуулаад элдэв янзын юм оруулах хамгаалалт хүртэл ингээд байгаад байгаа юм.

Тэгэхээр нэн дээр бид нар Хууль зүйн сайдтай бас энэ саналаа солилцсон. Ойлгосноор бол энэ Цахим, харилцаа хөгжлийн яам, Засгийн газар мөн дэмжиж туслалцаа үзүүлнэ гэж ингэж ойлгож байгаа. Мэдээж бэлтгэл ажлын хүрээнд бид нар нэлээн эрчимтэй явахгүй бол Сандаг-Очир гишүүний хэлж байгаагаар бас асуудлууд гарна. Тэгэхээр эхлээд дээрээсээ эхэлье гэж байгаа юм. Юу юугүй анхан шат руу орохоосоо өмнө эхлээд Улсын дээд шүүхээс эхэлье, ганц шүүх байна. Улсын дээд шүүхийн Захиргааны танхимын шүүх хурлуудыг нээлттэй болгоё. Ингээд нэг ёсондоо туршилт маягаар. Болж байвал эрүү рүүгээ, иргэн рүүгээ, магадгүй дараа нь доошоо давах руугаа юм уу ингээд үе шаттайгаар явъя гэж байгаа юм. Техник, тоног төхөөрөмж юмаа бүрдүүлээд энэ чинь бас төсөв хөрөнгөтэй холбоотой юм шиг байна.

Хоёрдугаарт гэвэл энэ юуг асуугаад байна тэр олон нууцын хуулиуд гээд. Бид нар энийг бас нэлээн судалгаа хийгээд нэн ийм гаргалгаа олсон юм. Тэр нь юу вэ гэхээр Хувь хүний мэдээлэл хамгаалах хууль, Төрийн болон албаны нууцын хууль, Байгууллагын нууцын хуулийг бол одоо нэг амьсгаагаар магадгүй сая Энхбаяр сайдын хэлснээр бас Засгийн газар дээр хүний эрхийг хамгаалах чиглэлээр бас өөрчлөлтүүд явах юм шиг байна. Эхний ээлжид ерөөсөө энэ хуулиудыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэхгүй гээд л ганцхан өгүүлбэрээр заагаад өгчхөөч гээд байгаа юм Шүүхийн хуульд.

Тэгэх юм бол тэр хувь хүний мэдээлэл нь хамгаалагддагаараа л хамгаалагдана. Гэхдээ шүүх дээр биш. Тэр байгууллагын нууц нь хамгаалагддагаараа хамгаалагдаад явж байг гээд тэр гадуураар. Яг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх энийг хэрэглэхгүй л гээд заагаад өгчих. Тэгэх юм бол бид нар энийгээ бас зохицуулах боломжтой болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхгүй бүх хуулиудаа энд нийцүүлээд ингэнэ гэхээр нэгдүгээрт цаг хугацаа, хоёрдугаарт энэ чинь өөрөө гол нь зохицуулах зүйл, зохицуулалтын харилцаа нь өөр юм.

Жишээлбэл, бид нар хууль зүйн системчлэлийн аргаар хуулийг тайлбарладаг. Үүгээр аваад үзвэл Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийн зохицуулах зүйл нь юу вэ гэхээр хүний эрхийн үүднээс хувь хүн өөрийнхөө мэдээллийг өөрөө хамгаална, зөрчигдөх юм бол төр эрхийг нь сэргээнэ. Өөрөөр хэлбэл, гуравдагч этгээд хүний хувийн мэдээллийг хууль бусаар олж аваад тараасан байвал тэрийг хариуцлага тооцно гэж байгаа юм.

Гэтэл шүүх бол энэ хуулийн харилцаанд ордог этгээд биш байхгүй юу. Тэгэхээр энэ хуулиа зүгээр энд ашиглахгүй, энэ шүүхийн процессст энэ хуулийг хэрэглэхгүй, шүүхийн нээлттэй, ил тод байдал, процесс нь өөрийнхөө тэр процессын хуулиар явна шүү гэдгээ л заачихвал энэ олон хуулиудыг бид нар ингээд шүүхтэй нийцүүлэх гээд байх боломжгүй. Угаасаа нийцэх ч боломжгүй энийг.

Тэгэхээр яах вэ энэ саналаа бид нар хууль санаачлагчид яг санал дээрээ бүүр тодорхой бичээд хүргүүлчхээд байгаа юм. Тэгэхээр ийм байдлаар бас яаж болохоор байгаад байгаа юм. Энийг дагаад шүүхийн цахимжилт яригдана. Шүүхийн ерөнхий зөвлөл дээр маш том ажлын хэсэг гараад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл ингээд хамтраад цахимжилттай холбоотой маш олон ажлууд энэ 23 оны 6 сараас

хойш явж байна. Хуулиуд нь төслийн хэмжээнд ороод энэ хуультай зарим нь орж байна. Зарим нь ингээд ар араасаа явж байгаа.

Тэгэхээр бид нар 25 оны 1 сарын 1 гэдэг төсөөлөлтэй байгаа. Үүнээс хойш магадгүй төсөв хөрөнгөөсөө болоод тоног төхөөрөмжөө авч чаддаггүй ингээд жсоохон бэлтгэл ажил сунжрахыг үгүйсгэхгүй. Энэ бол гарцаагүй яг шүүхээс өөрөөс нь шалтгаалахгүй ийм юунууд байхыг үгүйсгэхгүй байгаад байгаа юм.

Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Энэ дээр нээрээ нэг юм хэлчихье. Сандаг-Очир гишүүн бас яг эхнээсээ шүүх дээр анх энэ асуудлыг очоод ярьж байхад, очиж оролцоод, яриад эхнээсээ дэмжиж явсан гишүүн байгаа. Саяын энэ Сандаг-Очир гишүүний ярьсан төсвийн асуудал бол нээрээ чухал. Энхбаяр сайдаа энэ хууль батлагдаад гарсны дараа энэ төсөв мөнгөн дээр нь мэдээж богино хугацаа үлдсэн байгаа ч гэсэн эхнээсээ анхаарч явах ёстой.

Яагаад гэхээр энд би нэг л дараа нь сонсмооргүй байна. Ийм сайхан хууль гаргачихсан чинь төсөв мөнгө нь байхгүй учраас хэрэгжих боломжгүй байна гээд. Тэр тэгэхлээр юу болж хувирах вэ гэхлээр байна шүү дээ энэ чинь бид нарын ардаа яг хамгийн гол тулгамдаад байгаа асуудал авлигатай, авлигачидтай тэмцэх тухай асуудал ярьж байна шүү дээ.

Тэгэхлээр авлигачдын мөнгөнд төр дийлдээд байгаа юм шиг, авлигачид төрөөс илүү мөнгөөрөө өөрийн боломжийг хангаад байгаа юм шиг ийм нөхцөл байдал ёстой үүсэж болохгүй. Тэдэнд мөнгөнд нь дийлдэнэ гэдэг ойлголт байхгүй шүү. Тэгэхлээр мэдээжийн хэрэг шударга ёс хуулийг тогтооно гэдэг өөрөө ардаа зардалтай, төсөвтэй. Тэрийг нь ажиллах боломжийг нь заавал хангаж өгөх энэ тал дээрээ нээрээ засаг анхаарч ажиллах

ёстой шүү. Тэр юм дээр Энхбаяр гишүүн бас сая санал хэлье гэж байна. Энэ яг төсөвтэй холбоотой юун дээр та богино хугацаанд ч гэсэн нэлээн анхаараад ажиллаад өгөөрэй.

Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Сайдын.

**Б.Энхбаяр:** Шүүхийн захирамжлалыг Засгийн газар, Ерөнхий сайд ёстой тултал нь дэмжиж байгаа. 2024 оны Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн төсөлд хэлэлцэж байх үед буюу өнгөрсөн оны намар Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанд хэлэлцэж шүүхийн цахимжуулахтай холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан саналаас 1 ч төгрөг хасахгүйгээр 100 хувь шийдвэрлэх улс төрийн шийдвэр гаргасан. 24 оны төсөв бол шүүхийн цахимжилтыг 100 хувь шийдэх төсөв батлагдсан. Одоо бол хэрэгжилтээ хангаж байгаа байх гэж би бодож байна.

Нөгөө талаар гол асуудал юунд байна вэ гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл улсын төсвийн бүрэлдэхүүн хэсгээр энэ хүрээнд шийднэ. Мөн Монгол улсын Дээд шүүхийн хамтын ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улстай хөнгөлөлттэй зээлийн хүрээнд шүүхийн цахимжуулалтыг иж бүрэн шийдэх модель, төслийн асуудал бас яригдаж байгаа юм. Тэгэхээр 2 шугамаар энэ асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажиллаж байгаа.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Амартүвшин гишүүнээр хаалаа. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Б.Энх-Амгалан:** Энэ шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дэмжиж байгаа. Энэ хуулийг би зарчмын хувьд дэмжинэ.



Сая Мөнхтуяа шүүгчтэй би санал нэг байна бүх талаар. Тэр 12.16-г авч хаях ёстой, мөн хэлэлцүүлгийн явцад таны хэлээд байгаа тэр олон хуулийг бүгдийг нь өөрчлөх биш, шүүх яг тэр үедээ өөрөө шийдвэрээ гаргаад явчихдаг ийм боломжийг нь нээж өгөхгүй бол энэ хуулийн ач холбогдол гарахгүй гэж би бодож байна.

Энэ явцад хэдэн юмыг бас энэ хууль дээр оруулж өгмөөр байгаа юм. Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, дээр нь энэ шүүх хуралдааны тэмдэглэл, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шүүх хуралдааны бичлэг, тэр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явж олж авсан нотлох баримт, бичлэг, тэр байцаалтын бичлэг энэ тэрийг зүгээр л авдаг баймаар байгаа юм. Тэр өмгөөлөгч болоод тэр талуудын хүмүүс авч, тэр өмгөөллөө хангах эрхийг нь хангахгүй бол хязгаарлагдмал эрхээр ингэжээд тэр дотроо зөвхөн яллахыг нь давамгайлаад цагаатгахыг нь давамгайлахгүй нэг талаа бариад явчхаж байгаа энэ юм чинь эргээд хүн хэлмэгдүүлэх юм руугаа орчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яг энэ дээр маш тодорхой тусгаж өгөх асуудал чухал байна гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт нь түрүүн бас 3 номер дээр сууж байсан шүүгч хэлээд байсан энэ 3 өдрийн хуралдаан, 4 өдрийн хуралдааны чинь юмыг эсвэл бүгдийг нь гарга, эсвэл гаргаж болохгүй гэхээр зэрэг наадах чинь ерөөсөө гарахаа байчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ тодорхой нэг хэсэгтэй холбоотой юмаа тухайн хүн яг энэ хэсэг дээр ингэж ярьсан байхгүй юу гэдэг юмаа гаргах тэр эрхийг нь яаж нээх вэ? Тэр нь тэгэхдээ эвлүүлэхгүй, таслахгүй, утгыг нь алдагдуулахгүй шүүхийн гаргасан итгэл үнэмшилээр гаргасан шийдвэрт буруугаар нөлөөлчихгүй, хөндлөнгөөс нөлөөлчихгүй байхаар яаж гаргах вэ гэдэг юмаа бас

бодохгүй бол энэ маань өөрөө ингээд энүүгээрээ эсвэл чи 4 өдрийн бичлэгийг дөрвүүлийг нь гарга, эсвэл юу ч байхгүй гэдгээрээ хаагдах бас нэг ийм юм нээгдчихээд байгаа юм.

Гурав дахь нь юу юм гэхээр зэрэг би түрүүн хэллээ энэ шүүхийн тэр өдөрт болж байгаа 150 хэрэгтэй холбоотой юмыг ингээд гаргаад байвал энэ платформ дээр чинь зөвхөн ингээд л хэдэн олон ангит кино үзэж байгаа юм шиг л юм болох юм байна. Тэгэхээр энийг нь цахим архивлаад авдаг юм нь яаж хийх вэ? Цааснаас жоохон салах юмаа яаж хийх вэ? Тэгээд шаардлагатай бол тэрийгээ буцааж татаж авчраад үзэхэд тэр юмнууд хүчин төгөлдөр байдаг тэр бар кодыг нь хийдэг юмаа яаж хийвэл зөв байх вэ? Энэ хялбаршуулсан юмаа явал их зөв зүйтэй байх вэ гэдэг юмаа хэдүүлээ энэ дээрээ бас нэлээн сайн харж явахгүй бол болохгүй юм байна гэж ингэж бодож байгаа юм.

Нэгэнт нээлттэй болгож байгаа бол тэр Мөнхтуяа шүүгчийн хэлсэн тэр 12.16 болоод сая шүүх энийг хэрэглэхгүй гэдэг тэр юмыг энд оруулчихвал шүүх яг түрүүгээрээ явчихна. Бага насны хүүхдийг хүчиндсэн ч байдаг юм уу, төрийн нууцтай холбоотой, албаны нууцтай холбоотой, улс орны үндэсний аюулгүй байдалтай холбоотой, эсвэл төрийн тусгай албаны нууцтай холбоотой энэ би тагнуулын хэргийг хэлж байна шүү дээ. Ийм асуудлууд нь хаалттай байдаг л юм байгаа биз. Тэрийгээ тухайн үед нь зохицуулаад, бусад юмыг нь нээлттэй, аль болох нээлттэй болгож өгөхгүй бол нэг өмгөөлөгч хүсэлт гаргаад л хаачихдаг, эсвэл хэргийн оролцогч хүсэлт гаргаад л ингээд л хаачихдаг байвал энэ дахиад нээлттэй болохгүй. Ингэж нээлттэй болгож байж олон түмэнд ямар ч байсан шүүх дээр очиход үнэн мөнөө таниулна, энэ үнэн мөнөө ялгагдах байх гэдэг тийм итгэл үнэмшил төрүүлэхгүй бол миний түрүүний хэлээд байгаа бид нар асуудлаа шийдээд явуулчихсан, дутуу хаахаар хэрэг боож явуулчихаад л янзтай юм

сайхан боож явуулсан, шүүх яахыг харна, та нар хараад байгаарай шүүх яг ингэж шийднэ гээд л. Ингээд л бүх юм шүүхийн буруутай юм шиг болоод ингээд явчхаж болохгүй учраас энэ нээлттэй байгаа шүүхийн өөрийнх нь санаачилгыг дэмжиж байна.

Бид нар нээлттэй болоод өгье л дөө, та нар энэ боломжоор төр хангаадах л даа гэж хэлж байгаа энэ шүүгч нарын энэ хүсэл, эрмэлзэл дээр их баяртай байна. Яг ингэж явах ёстой цаашдаа. Тэгвэл наадах чинь шийдвэр үнэн болно, олон нийтэд нээлттэй болно. Хэн нь зөв, хэн нь буруу гэдэг нь бол хэний ч өмнө ил болно. Тийм учраас энийг бол би дэмжиж байгаа юм. Ажлын хэсэг дээр бас би зарчмын зөрүүтэй саналууд гаргана. Шаардлагатай бол 12.16-аар би зарчмын зөрүүтэй санал гаргаж, энийг бас авч хаях ёстой, эсвэл өөрчлөн найруулах ёстой гэж ингэж бодож байна. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Ер нь бид нар энэ шүүгч, шүүх, шүүхийн институцийн нэр хүнд, иргэдийн итгэх итгэлийг хамгаалах ёстой байгаа юм. Дэмжих ёстой. Энэ хуулийн төслийг орж ирж байгаад би бас 100 хувь дэмжиж байна. Энэ бол маш зөв санаа, санаачилга байна. Ер нь шүүх энэ процесс нь өөрөө тийм ойлгомжгүй, нууцлаг явагдахаар иргэдийн хардах тэр хандлага нь нэмэгдээд байгаа юм л даа. Энэ худлаа, буруу шүүчихлээ, ямар нэгэн нөлөөнд ороод ингээд ял өгчихлөө ч гэдэг юм уу, аль эсвэл цагаадчихлаа ч гэдэг гэдэг ч юм уу ийм нөхцөл байдлыг бид нар өөрчлөх ёстой. Нууцтай холбоотой асуудал дээр Мөнхтуяа шүүгч болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн энэ саналуудыг ажлын хэсэг дээр ер нь хүлээж авсан нь зөв санагдаад байна л даа. Өнөөдөр бид нар нэлээн ярилцлаа.

Яагаад гэвэл яг үнэндээ хэлэхэд энэ нууцтай холбоотой асуудал чинь ер

нь аягүй өргөн цар хүрээтэй юм байна лээ шүү дээ. Жишээлбэл, Монголбанк 10, 20 жилийн өмнө дампуурсан арилжааны банкны тайланг нууц гээд тамга дарчихсан. Тэнд ямар нэгэн нууц мэдээлэл огт байхгүй байхгүй юу. Яагаад тийм асуудал нууц байх ёстой юм. Харин ч эсрэгээр энэ чинь арилжааны банк чинь иргэдийн, аж ахуй нэгжүүдийн мөнгөөр бизнес хийдэг байгууллагын энэ асуудал илт нээлттэй байх ёстой шүү дээ гэх мэтчилэн ийм үзэмжээрээ нууцын дардас дараад нууц гээд ангилчихдаг ийм асуудлуудыг цэгцлэх цаг нь болсон. Энхбаяр сайдын хэлж байгаа одоо ийм өөрчлөлт орох юм байна гэж бид ойлголоо.

Тэгэхлээр энийг бас дэмжих нь зүйтэй. Ер нь би энэ Шүүх байгуулах тухай хуулийн ажлын хэсгийг ахлаад ажилласан энэ шүүх, шүүгчдийн, шүүх институцийн төсөв мөнгөний асуудал, тэр ачаалал, ажиллаж байгаа нөхцөл дээр үнэхээр бид нар анхаарах ёстой юм байна лээ шүү. Тэгж байж энэ чинь шүүхийн бас боловсон хүчний чанар нь сайжирна, цалин хөлс нь дагаж өсөх хэрэгтэй. Ачааллын асуудлыг нь бид нар шийдэхгүй гэвэл тэр хүмүүс чинь үнэхээр зарим нь ачааллаа дийлэх ямар ч боломжгүй болчихсон байна лээ шүү дээ. Тэгэхлээр энэ дээр Их Хурал болон Засгийн газар анхаарч ажиллаасай. Энэ 25 оны төсөв ерөнхийдөө хэлэлцэж эхэлж байгаа яамдын түвшинд энэ дээр бас Засгийн газраасаа анхаарч, дэмжиж өгөөрэй гэж хэлмээр байна. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Би үг хэлээдэхье. Энэ дээр нэг зүйлийг яримаар байна. Ер нь ийм юм байгаа юм бас. Шүүгч бол шийдвэрээ өөрийнхөө, ингээд сая гишүүд яриад байна шүү дээ ингэчихлээ гээд нийгмээрээ баахан урьдчилаад нийгэм шүүхийн хэмжээний баримт, мэдээлэлтэй танилцаагүй байж байгаа шүү дээ. Тэгэхэд нийгмээрээ баахан хүнийг байхгүй болгож хаячхаад, тэгэнгүүтээ одоо шүүх яаж шийдэхийг харья гээд энэ бол шүүхэд шууд нөлөөлөх гэж байгаа оролдлого. Ялангуяа улс

*төрчдийн амнаас ийм юм гарч байгаа бол энийг тэгж харах ёстой.*

*Тэгэхлээр би энэ дээр юу хэлмээр байна гэхлээр би шүүгчид бол дотоод энэ итгэл үнэмшилээрээ баримт дээр хуулиа барьж, шийдвэрээ зоригтой гаргацгааж байх ёстой. Түүнээс одоо энийг гаргачихвал нийгэм намайг бариад идэх юм байна, би нийгэмд бариулж идүүлэхгүйн тулд хэнийг ч хэлсээр ингээд шийтгэж болохгүй тийм хандлага нээрээ байж болохгүй шүү. Монгол улсын шүүгч тангараг өргөсөн шүүгчид байж байгаа. Тэр тангарагтаа үнэнч, хуульдаа үнэнч, Үндсэн хуульдаа үнэнч, тэр дотоод итгэл үнэмшилдээ итгэлтэй. Харин ёстой гарч ирээд нэг боломжийг нь олгож өгч байх ёстой. Тэр ингээд дайраад байгаа бол Шүүхийн ерөнхий зөвлөлөөс уу хаанаас вэ тэр байгууллагаа хамгаалаад баримт чинь ийм байна шүү дээ хөдөлгөөнгүй, ийм юман дээр өөр ямар шийдвэр гаргах юм, ийм учраас ингэж шийдвэр гаргасан юм гээд зоригтой тэрийг нь яриад, хэлээд өгч байх. Тэр шүүгч нь өөрөө ярьж чадахгүй байж болно. Өмнөөс нь тэр яриад хэлээд өгч байх танайх спокс персон /spokes person/ гэж байдаг шүү дээ тээ. Тэр институцээ түргэхэн яаралтай бий болгоод энэ юмнууд дээрээ анхаарч ажиллах ёстой шүү.*

*Энэ дээр түрүүн Сандаг-Очир гишүүн ч хэлж байна. Тэр нээлттэй бүүр тусгай суваг байх уу, яах вэ гээд. Шүүх дээр би очиж ажиллаж байхдаа яг энэ бас асуудлыг ярьж байсан. Тийм, тэгж тийм. Тэгэхлээр яг энэ юмыг та нар хийж ажиллаарай. Тэгж байж шийдвэрээ бас олон нийтийн өмнө хамгаалж байхгүй бол наадах чинь суурь тэр итгэлийн, бүхэл бүтэн төрийн институцэд итгэх итгэлийн асуудал гарч ирж яригдаад байна шүү.*

*Тэр иргэдийн нууцтай холбоотойгоор би нэг зүйлийг хэлмээр байна. Ер нь нууц бол ийм гэж би ойлгож байгаа. Түрүүн Мөнхтуяа гишүүн ч хэлж байна. Энэ субъектүүдийн хоорондын эрх, үүргийн энэ ялгаагаа хэдүүлээ сайн*

*ойлгож авч байх нь бас зөв байх. Шүүх нээлттэй боллоо гээд хувь иргэний нууцын асуудал нээлттэй болж байгаа биш шүү дээ. Шүүх дээр очин очтолоо иргэний асуудлууд тэр нууц хэвдээ л байна. Хэрэв маргаанд орчхож байгаа бол тэгээд шүүх дээр яваад очиж байгаа бол асуудал чинь нээгдэх нь байна шүү гэдгээ л иргэд ойлгож байх ёстой.*

*Түүнээс өөрөөр хэлбэл, тэр нууцын хууль Монгол улсын үндэсний аюулгүй байдал, тагнуул, тэр мөрдөн шалгах үйл ажиллагаатай холбоотой л биш бол бусад бүх юм чинь шүүх дээр ирээд нээлттэй болно шүү гэдгийг л тал талдаа ойлгомоор байгаа юм. Түүнээс иргэдийн нууц энэнээс болоод эрүүл мэндийн юм уу, хувийн нууц нь нээлттэй болж байгаа гэж байгаа биш. Шүүх дээр ирвэл л нээлттэй болно. Бусад үедээ хаалттай. Тэр нууцлалын хууль, журмаараа шахагдаад явна шүү гэдгээ л бас тал талдаа ойлгож авах ёстой гэж бодож байна. Энэ өнцгөөсөө ч гэсэн энэ ажлын хэсгийн хэлэлцүүлэг дээр цаашид яриад явж байхдаа энийгээ бас тодотгож ярьцаагаарай гэж хэлмээр байна.*

*Ингээд санал хураалт явуулъя. Хуулийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Улсын Их Хурлын гишүүн Занданшатар, Тогтохсүрэн, Учрал, Цогтбаатар нарын гишүүд 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.*

*58 хувийн саналаар санал дэмжигдлээ.*

*Тэрийгээ би хамтатгаад хэлчихье. Манай гишүүд түр байж байгаарай. Одоо ганцхан асуудал байгаа шүү.*

Гишүүд ээ түр байж байгаарай. Ингээд санал хураалт, сая би санал хураалтын дүнг танилцуулсан тээ? 58 хувиар батлагдсан шиг санаж байна. 57.9 хувиар батлагдлаа. /хуралдаан даргалагч санал хураалтын дүн 58.3 хувь байсныг дэлгэц гялбаад буруу танилцуулав./

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна.

Шүүх байгуулах тухай хуулийн энэ эцсийн хэлэлцүүлэг явуулсан тухай санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд Амартүвшин, Бямбацогт гишүүн танилцуулна. Гурав дахь асуудалдаа оръё.

12.00 цаг

**Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай, Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Н.Жамъянхүү Хууль зүй, дотоод

хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны газрын дарга, Ж.Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдөр хуралдаанд ирж. Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Хуулийн төсөл санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулна. Энхбаяр гишүүнд микрофон өгье.

**Б.Энхбаяр:** Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 сарын 21-ний өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөх хүсье.

Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Алга байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Алга байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулья.

Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

66 хувиар санал дэмжигдлээ. 66.7 хувиар.

Хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Оролцсон гишүүддээ талархал илэрхийлж байна.

12.04 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР